

Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалт: Хөрөнгө оруулалтын орчны харьцуулсан судалгаа

**З. Манлайбаатар
Т. Дөлгөөн**

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн (ЭЗСЭШХ)

Хураангуй

Байгалийн баялагтай хөгжиж буй орнуудад гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)-ийн урсгалыг тодорхойлогч гол хүчин зүйл нь хөрөнгө оруулалтын орчин, ашигт малтмалын нөөц байдаг. Ашигт малтмалын нөөц нь үл өөрчлөгдөх хүчин зүйл учраас улс орнууд хөрөнгө оруулалтын орчноо сайжруулах замаар гадаадын хөрөнгө оруулагчдыг татахыг зорьдог.

Энэхүү судалгааны зорилго нь Монголтой төстэй улс орнуудыг сонгон, хөрөнгө оруулалтын орчны шинжилгээ хийж, улс орнуудын сайн туршлагад суурилсан зөвлөмж боловсруулах юм. Судалгаанд Казакстан, Перу, Замби улсыг харьцуулалт хийхээр сонгосон. Энэ гурван улс хэд хэдэн шинжээрээ Монголтой нэлээд төстэй. Нэгдүгээрт, бүгд дунд орлоготой орнууд. Хоёрдугаарт, эдийн засгийн хувьд уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбараас хүчтэй хамаардаг. Гуравдугаарт, уул уурхайн салбар сүүлийн 20-30 жилд эрчимтэй хөгжиж байгаа. Казакстан, Перу улсууд Бизнес эрхлэлтийн индекс, Авлигын төсөөллийн индекс, Хөрөнгө оруулалт татах индекс зэрэг олон улсын байгууллагуудаас гаргадаг үзүүлэлтээр харьцангуй сайн үнэлэгддэг. Иймээс эдгээр улс тулгарч буй саад бэрхшээлээ хэрхэн даван туулж байгаа нь Монголын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад чухал жишээ сургамж болно гэж үзэж байна.

Түлхүүр үгс:

Хөрөнгө оруулалтын орчин, институцийн шинжилгээ, гадаадын шууд хөрөнгө оруулалт, уул уурхай, байгалийн нөөц, Монгол, Казакстан, Перу, Замби

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн



Монгол дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалтын орчны харьцуулсан судалгаа

Улаанбаатар

Монгол дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт:
Хөрөнгө оруулалтын орчны харьцуулсан судалгаа

Судлаачид:

**З.Манлайбаатар
Т.Дөлгөөн**

Улаанбаатар, 2019

Гарчиг

Товчлолын жагсаалт.....	4
Удиртгал.....	5
1. Хөрөнгө оруулалтын орчин	6
1.1. Монгол улс	6
1.2. Казакстан	9
1.3. Перу.....	10
1.4. Замби.....	11
1.5. Бизнес Эрхлэлт 2019.....	12
1.5. Авлигын төсөөллийн индекс.....	14
2. Олборлох үйлдвэрлэл дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт.....	17
2.1. Монгол улс	17
2.2. Казахстан	18
2.3. Перу.....	19
2.4. Замби улс	20
2.5. Хөрөнгө оруулалт татах индекс.....	21
3. Харьцуулсан шинжилгээ	24
4. Дүгнэлт ба зөвлөмж	27
Ашигласан ном, товхимол	29

Товчлолын жагсаалт

АОУСТ	Астана Олон улсын санхүүгийн төв
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ОУВС	Олон улсын валютын сан
АМГТГ	Ашигт малтмал газрын тосны газар
ОРЕС	Газрын тос экспортлогч орнуудын байгууллагаа
ДХБ	Дэлхийн худалдааны байгууллагаа

Удиртгал

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн гүйцэтгэсэн “Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт” (ЭЗСЭШХ, 2017) суурь судалгаагаар гадаадын шууд хөрөнгө оруулалтад (ГШХО)-д нөлөөлөгч гол хүчин зүйлсийг тодорхойлох замаар ГШХО-ын Монголын эдийн засаг дахь нөлөөллийг хэмжиж, хэрхэн сайжруулах талаар судалсан. Улмаар дээрх суурь судалгааны үргэлжлэл судалгаагаар Монгол ба Чилийн хөрөнгө оруулалтын орчны индексүүдийг шинэчилж, худалдааны нөхцөлийг харьцуулсан (ЭЗСЭШХ, 2018). Энэхүү цуврал судалгаанаас гарсан гол дүгнэлт бол Монгол дахь ГШХО эрдэс түүхий эдийн үнээс хүчтэй хамаардаг бөгөөд Монголын бодлогын талаарх хүлээлт сул байдаг нь хөрөнгө оруулалт татахад гол саад учруулж байна¹. Ерөнхийдөө Монголын институцийн болон хөрөнгө оруулалтын орчны хөгжил Чилитэй харьцуулахад тааруу хэвээр байна.

Харин энэ удаагийн нэмэлт судалгаагаар, зарим ижил төстэй орны хөрөнгө оруулалтын орчныг шинжилж, тэдний сайн туршлагад суурилсан, Монголд хэрэглэж болохуйц зөвлөмж боловсруулахыг зорилоо. Өмнөх нэмэлт судалгаанд дурдсанаар, Чилийн уул уурхайн салбарын хөгжил олон арван жилийн түүхтэй бол Монголын уул уурхайн үйлдвэрлэл харьцангуй шинэ хөгжиж буй салбар юм. Жишээ нь, Чилийн зэсийн үйлдвэрлэл дэх хөрөнгө оруулалт 1900-аад оны үед эрчимжиж эхэлсэн байдаг (Schmitz, 1986). Мөн Дэлхийн банкны тодорхойлолтоор, Чили бол өндөр орлоготой улс. Харин Монгол Улс дундаас доогуур орлоготой гэсэн ангилалд багтаж байна (World bank, 2018). Чили нь байгалийн баялгаа зөв удирдсан сайн жишээ болдог. Иймээс Монгол Улс урт хугацаандаа Чилийн түвшинд хүрэхийг эрмэлзэх ёстой. Харин гадаадын хөрөнгө оруулалт татахын тулд богино ба дунд хугацаандаа ямар бодлого баримтлах, эсвэл ямар бодлогоос татгалзах вэ гэдгээ тодорхойлохын тулд монголчууд уул уурхайн хөгжил, эдийн засгийн салбарын хувьд ижил төстэй улс орнууд болох Казахстан, Перу, Замби зэрэг улсын уул уурхай, эдийн засгийн салбарт дүн шинжилгээ хийх шаардлагатай.

Энд сонгосон гурван улс Монголтой нэлээд олон зүйлээр төстэй. Нэгдүгээрт, бүгд дунд орлоготой. Хоёрдугаарт, эдийн засгийн хувьд уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбараас хүчтэй хамаардаг. Гуравдугаарт, уул уурхайн салбарын хөгжил сүүлийн 20-30 жилд л эрчимтэй явагдаж байгаа.

Казахстан, Перу улсууд Бизнес эрхлэлтийн индекс, Авлигын төсөөллийн индекс, Хөрөнгө оруулалт татах индекс зэрэг олон улсын байгууллагуудаас гаргадаг үзүүлэлтээр харьцангуй дээгүүр үнэлэгддэг. Иймээс эдгээр орон ойрын ирээдүйд Монголд тулгарч болох ижил төстэй саад бэрхшээлийг хэрхэн даван туулж байгааг анхаарч судалснаар эдгээр туршлагыг Монголын институц болон хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад нэвтрүүлж болох юм.

¹ Эдгээр судалгааны тайлан Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн цахим хуудаст нийтлэгдсэн (www.eri.mn).

1. Хөрөнгө оруулалтын орчин

Байгалийн баялагтай хөгжиж буй орнуудын хувьд ГШХО-ийн орох урсгалыг тодорхойлогч гол хүчин зүйл бол баялгийн нөөцөөс нь гадна хөрөнгө оруулалтын орчин байдаг. Хөрөнгө оруулалтын орчныг ГШХО-тай холбоотой бодлого, хууль тогтоомж, өрсөлдөх чадвар, худалдааны саад бэрхшээл, авлига гэх мэт зохицуулалтын болон институцийн олон хүчин зүйлээр тодорхойлдог. Түүнээс гадна гадаадын хөрөнгө оруулагчид болон байгалийн нөөцийн ашиглалт, зохицуулалтын орчны хувьсал хөгжилд тухайн улсын түүх бас чухал нөлөөтэй. Хууль эрх зүйн тогтолцооны суурь үндэс бүрэлдэхэд засаглалын түүхэн хэлбэрүүд (хаант засаг, коммунизм, дарангуйлал гэх мэт) хүчтэй нөлөө үзүүлдэг.


1.1. Монгол

Монголчууд 20-р зууны эхээр Манж Чин улсын эрхшээлээс гарсны дараа Хаант Орос, улмаар Зөвлөлт Холбоот Улсын нөлөөнд орсон билээ. Ингэснээр Монголын улс төрийн тогтолцоо тухайн үеийн Зөвлөлт засгийн хэв маягийг дагах болсон. Харин 1990-ээд оны эхээр Зөвлөлт Холбоот Улс задрахтай зэрэгцээд Монголд ардчилсан хувьсгал өрнөж, 1992 оны шинэ Үндсэн хууль батлагдаж, зах зээлийн эдийн засагт шилжих өөрчлөлт эхэлсэн. Гэвч улс төр, нийгмийн хүрээнд социализмын үеийн нөлөө хүчтэй хэвээр байсан.

Сүүлийн гучин жилд Монгол Улс хөгжингүй орнууд, олон улсын байгууллагуудын тусламжтайгаар хууль, институцийн тогтолцоогоо бие даан шинэчлэх оролдлого хийж байна. Засгийн газар гадаадын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, худалдааг төрөлжүүлэх арга хэмжээг идэвхтэй хэрэгжүүлэхээр хичээж байна. Орос, Хятад гэсэн хоёр том улсын хооронд хашигдсан орны хувьд экспортын гарц, зах зээлд нэвтрэх суваг энэ хоёр улсаар хязгаарлагддаг. Монголын уул уурхайн салбарын экспорт Хятадын эрэлтээс голчлон хамаардаг. Харин дотооддоо газрын тос боловсруулах үйлдвэрлэл байхгүй учраас түлш шатахууны импортын 90 гаруй хувийг Оросоос импортолж байна.

Эдийн засаг уул уурхайн салбараас ихээхэн хамааралтай тул Монголын засгийн газар аялал жуулчлал, хөдөө аж ахуй, цахим худалдаа зэрэг бусад салбарт хөрөнгө оруулалт татах зорилгоор стратеги, төлөвлөгөө боловсруулсан. Гэвч эдгээр төсөл үр ашиггүй, санхүүжилт хүрэлцээгүй байдал нь гол бэрхшээл болдог.

Зураг 1. ГШХО салбараар 2018 он, сая ам.доллар




Эх сурвалж: YCX

Жишээлбэл, 2018 онд Монголд орсон 2.5 тэрбум ам.долларын ГШХО-ын 71 хувь буюу 1.8 тэрбум ам.доллар зөвхөн уул уурхайн салбарт оржээ. Уул уурхайн салбар дахь ГШХО-ын ихэнх хэсэг Оюу Толгой төсөлд орж байгааг доорх зургаас харж болно.

Шигтгээ. Оюу Толгой

Оюу Толгой бол үйл ажиллагаагаа явуулж буй хамгийн том уурхай бөгөөд Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын гол суваг юм. 2010-2015 онд Оюу Толгой Монгол Улсад 5.4 тэрбум гаруй ам.долларыг цалин, дотоодын ханган нийлүүлэгчдэд төлөх төлбөр, засгийн газарт төлөх татвар, хураамж хэлбэрээр зарцуулжээ.

Зураг 2. Оюу Толгойн ГШХО, тэрбум ам.доллар




Эх сурвалж: Оюу Толгой, Улсын нэгдсэн төсөв 2019

Уг төсөл 2015 онд 4.4 тэрбум ам. долларын багц санхүүжилтийг далд уурхай барихад зарцуулахаар шийдвэрлэсэн. Зээлдэгчдийн тоонд BNP Paribas, Export Development Canada гэх мэт арилжааны банкнуудаас эхлээд олон улсын санхүүгийн байгууллагууд хүртэл багтжээ.

Сүүлийн арван жилд Монгол дахь ГШХО-ын идэвхжил огцом нэмэгдээд, эргээд саарсан мөчлөг шинжтэй байна. ГШХО-ын орох урсгал уул уурхайн салбарын өсөлтөөс шалтгаалан огцом нэмэгдсэн ба үүнд Оюу Толгойн ил уурхайн бүтээн байгуулалт голчлон нөлөөлсөн. Гэвч 2011 оноос хойш түүхий эдийн үнэ буурахын зэрэгцээ хөрөнгө оруулагчдын Монголд итгэх итгэл суларсны улмаас ГШХО буурчээ.

Зураг 2. Монгол дахь ГШХО, 2008-2018, тэрбум ам.доллар



Source: Bank of Mongolia

2011 оноос тасралтгүй буурч байсан ГШХО-ын хэмжээ 2017 онд нэмэгдэж 1.5 тэрбум ам.долларт хүрчээ. Үүнд Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалтад чухал нөлөөтэй түүхий эдийн үнийн өсөлт голлон нөлөөлсөн. 2016 онд ГШХО 4.2 тэрбум ам.долларын алдагдалтай гарсны 3.8 тэрбум нь Оюу Толгойн хөрөнгө оруулалтын бичилт өөрчлөгдсөнтэй холбоотой. Монголын Засгийн газрын эзэмшдэг Оюу толгой төслийн 34 хувь нь 2009 оны анхны гэрээ

байгуулах үед ГШХО хэлбэрээр төлбөрийн тэнцэлд бүртгэгдсэн байсан. Харин 2016 онд энэхүү 34 хувийг ирээдүйн Монголын Засгийн газрын орлогоос эргүүлэн төлөх гадаадын зээл хэлбэрээр бүртгэж ангиллыг нь өөрчилсөн юм. Сүүлийн жилүүдэд макро эдийн засгийн байдал сайжирч, ашигт малтмалын үнэ өсөх төлөвтэй байгаа бөгөөд Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт Монголд орох ГШХО-ыг цаашид нэмэгдүүлэх хандлагатай байна.

Монгол Улсын татварын түвшин 2006-2016 онд тасралтгүй буурч ирсэн боловч байгалийн нөөцийн үндсэрхэг үзэл нэмэгдэж, уул уурхайн компаниуд татвараас зайлсхийсэн тухай шуугиан дэгдсэн тул засгийн газар цаашид уул уурхайн шинэ төслүүдийн гэрээнд татварын болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг өндөр тогтоох магадлалтай юм. 2017 оны 11-р сарын 10-нд Улсын Их Хурал Татварын ерөнхий хууль болон 2018 оны Төсвийн хуульд хамааралтай хэд хэдэн хууль тогтоомжид өөрчлөлт оруулсан. Тухайлбал, 2018 оны 1-р сарын 1-ээс газрын эрх, хайгуул, ашиглалтын лицензтэй аж ахуйн нэгжийг худалдвал "шууд бус шилжүүлэг" гэж үзэн татвар ноогдуулахаар болсон. Энэ худалдааг лиценз борлуулсны татвараас зайлсхийх нэг арга гэж урьд нь үздэг байсан юм. Хуулийн энэ нэмэлт өөрчлөлт нь лиценз түр эзэмшигчдэд бус харин эцсийн үр ашиг хүртэгчдэд татвар ноогдуулах анхны оролдлого бөгөөд ингэснээр эрхийн худалдааны талаарх түүхэн явцуу үзэл бодлыг халж байгаа хэрэг юм. Уг нэмэлт өөрчлөлтийг газрын эрх, ашигт малтмалын лиценз эзэмшдэг, аль ч салбарын бүх компани дагаж мөрдөнө.

Бизнесийн эрх зүйн мэдлэг, зах зээлийн туршлага муутай байдал нь Монголд гэрээний хэрэгжилт муу байхад хүргэдэг. Мөн шүүх хээл хахуульд автсан гэх ойлголт нийтлэг байдаг. Гэхдээ Монгол Улс бусад ижил төстэй орнуудтай харьцуулахад гэрээний хэрэгжилт, маргаан шийдвэрлэлт харьцангуй сайн үнэлэгддэг. Дэлхийн Банкны үнэлгээгээр, орон нутгийн анхан шатны шүүхээр бизнесийн жишиг маргааныг шийдвэрлэхэд шаардагдах хугацаа 374 хоног бөгөөд нийт нэхэмжлэлийн 23 орчим хувьтай тэнцэх зардал гардаг (World Bank, 2019). Үүнийг бүс нутгийн дундаж болох маргаан шийдвэрлэх дундаж хугацаа 581 хоног ба нэхэмжлэлийн 47 хувьтай тэнцэх зардалтай харьцуулахад сайн үзүүлэлт юм.

Монгол Улс 2016 оны 8-р сард Засгийн газрын түвшинд хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийг байгуулсан бөгөөд уг зөвлөл хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалтын маргааныг хэлэлцээрийн замаар шийдвэрлэхэд тулгарч буй хүндрэлийн талаар хөрөнгө оруулагчдын санал хүсэлтийг хүлээн авах ажээ. 2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хуульд хөрөнгө оруулагчийн хөрөнгийг хууль бусаар хураахаас хамгаалсан баталгаа гаргаж өгсөн ба хөрөнгийг хууль ёсоор дайчлан авсан тохиолдолд тухайн хөрөнгийн нөхөн олговрыг зах зээлийн үнэлгээгээр тооцож бүрэн төлөхөөр заасан. Үүнээс гадна, Монгол Улс бусад улстай байгуулсан хоёр талын 44 хэлэлцээрт гадаадын хөрөнгө оруулалтыг дотоодын хөрөнгө оруулалттай адил тэгш, ялгаварлалгүй, шударга хандахыг заасан байдаг. Эдгээр гэрээ нь эд хөрөнгийг дур мэдэн хураахаас сэргийлэх баталгааг өгдөг бөгөөд хураасан тохиолдолд олон улсын хууль тогтоомжийн дагуу нөхөн олгохыг шаарддаг.

Хувийн хөрөнгө оруулалтыг төрөөс албадан хураасан тохиолдлын нэг нь 2010 онд Канадын Хан Ресурс компани хууль зөрчөөгүй байхад нь эзэмшиж байсан ураны лицензийг цуцалсан явдал байв. Тус компани Монголын хуулийг зөрчөөгүй байсан тул олон улсын арбитрын шүүх дээр Хан Ресурс ялж, Монголын Засгийн газар их хэмжээний нөхөн төлбөр төлөхөөр болсон билээ.

Үе үеийн засгийн газрууд хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах арга хэмжээ авч ирсэн боловч хөрөнгө оруулагчдын илэрхийлж буй хандлага, улс орнуудын гадаадын хөрөнгө оруулалтыг татах чадварыг хэмждэг индексүүдийн үр дүнг харвал, эрдэс баялгийн үнийн савлагаа, улс төрийн болон хуулийн орчны тогтворгүй байдал, авлигал, ил тод бус байдал зэрэг нь Монголд хөрөнгө оруулалт орж ирэхэд саад учруулсаар байна.

1.2. Казакстан

Европ болон Ази тивийн дунд байрладаг Казакстан бол далайд гарцгүй улс юм. 1920 онд Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд орсон тус улсад хөдөө аж ахуйг хамтралын зохион байгуулалтад оруулж, хувийн бизнесийг нийгэмчилсэн. Бусад социалист улсын адилаар, намын бодлогыг Зөвлөлтийн хуулиар хэрэгжүүлэх ёстой бөгөөд улсын эдийн засгийг төвлөрсөн төлөвлөгөөгөөр удирдаж байсан. 1991 онд Казакстан улс тусгаар тогтнолоо зарлаж, Нурсултан Назарбаев ерөнхийлөгчөөр сонгогдсон. Хэдийгээр тус улс ерөнхийлөгчийн засаглалтай бүгд найрамдах улс боловч Назарбаев 29 жилийн турш тасралтгүй ерөнхийлөгчөөр ажиллаж, тус улс авторитар шинжтэй болж байна гэж үздэг.

Тус улс 20 хүрэхгүй жилийн дотор “дундаас доогуур орлоготой” ангиллаас “дундаас дээгүүр орлоготой” ангилалд дэвшжээ. Гэхдээ эдийн засаг нь хурдтай өссөн боловч гадаад шокийн нөлөө их байдаг тул тогтвортой хөгжилд ихээхэн саад учирдаг. Казакстаны худалдааны гол түншүүд болох Хятад, Оросын эрэлтээс гадна дэлхийн газрын тосны эрэлт болон үнэ эдийн засгийн хөгжилд гол нөлөө үзүүлдэг. 30 тэрбум баррель газрын тос, 85 их наяд шоо фут байгалийн хийн нөөцтэй Казакстан дэлхийн хамгийн их 15 байгалийн хий олборлогчийн нэг юм.

Эдийн засаг нь газрын тос болон олборлох аж үйлдвэрээс хэт хамааралтай болсон тул Казакстаны засгийн газар эдийн засгаа төрөлжүүлэхэд анхаарал хандуулах болсон. Тухайлбал, байгалийн баялгаас хараат байдлыг бууруулахын тулд засгийн газар газрын тосны бус салбаруудыг дэмжих, хөрөнгө оруулалт татахын тулд бүтцийн болон институцийн олон шинэчлэл хийжээ. 2015 оны 5-р сард ерөнхийлөгч Назарбаев “100 бодит алхам” хөтөлбөрийг зарласан. Уг хөтөлбөрт дөрвөн гол чиглэлийг томъёолсон. Үүнд нийтийн удирдлагыг мэргэжлийн түвшинд хүргэх, хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлт болон төрөлжилтийг дэмжих гэсэн чиглэлүүд багтжээ². Энэхүү хөтөлбөр нь тус улсыг 2050 он гэхэд 30 хөгжингүй орны нэг болох үндэсний зорилтыг дэмжихэд чиглэнэ.

2015 онд Казакстан Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-д гишүүнээр элссэн ба ингэснээр худалдааны саад бэрхшээл цаашдаа буурах боломжтой юм. Тус улс ДХБ-д албан ёсоор элсэх хүртэл 20 жил хэлэлцээр хийсэн. Элсэн орсны дараа хийсэн нэг шинэчлэл бол гадаадын иргэдийг ажилд авах журмыг хялбаршуулсан явдал байв.

Гадаадын хөрөнгө оруулагчдад тулгарч буй нэг бэрхшээл бол төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн давуу байдал юм (OECD, 2017). Үүнийг шийдвэрлэхийн тулд Засгийн газар 2016-2020 оны хувьчлалын иж бүрэн төлөвлөгөөнд тусгасан 800 гаруй компани, Samruk Kazyna³ компанийн зарим хувьцааг хувьчилж эдийн засагт засгийн газрын эзлэх хувийг 15 болгож бууруулах ажээ (Samruk Kazyna, 2018).

Урамшуулал

Казакстаны Аж ахуйн нэгжийн тухай хуульд зааснаар зарим салбарт гаалийн татвар, бусад татвар болон татварын бус хөнгөлөлт үзүүлж хөрөнгө оруулалтыг урамшуулдаг. 2014 оны 8-р сард ерөнхийлөгчийн зарлигаар хөрөнгө оруулалтын тэргүүлэх салбаруудыг баталсан. Үүнд 6 тэргүүлэх хүрээний 14 салбарыг тодорхойлж, хөрөнгө оруулалтын төрөл, байршил, үйл ажиллагаанаас хамаараад татварын үлэмж хөнгөлөлт олгожээ. Тусгай хөрөнгө оруулалтын

² “100 алхам” хөтөлбөрийн 74 алхам нь авлига ихтэй, ил тод байдал дутмаг гэж шүүмжилдэг олборлох салбарын ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн болно.

³ Samruk-Kazyna ХК нь 2008 онд Казахстан улсын Ерөнхийлөгчийн Зарлигаар үүсгэн байгуулагдсан ба цорын ганц хувьцаа эзэмшигч гэж тооцогддог. Samruk-Kazyna компани нь үндэсний хэмжээний эдийн засгийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг хэд хэдэн үндэсний компаниудыг удирдан явуулдаг, жишээ нь газрын тос, хий гэх мэт, тээвэр логистик, хими цөмийн аж үйлдвэр, уул уурхай, металлурги гэх мэт.

төсөл, тэргүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, стратегийн хөрөнгө оруулалтын төсөлд үзүүлэх татварын ба татварын бус хөнгөлөлтүүд өөр өөр байх ба хөрөнгө оруулагчид уг эрхийг олж авахын тулд холбогдох төрийн байгууллагатай хэлэлцээр хийх ёстой.

Дэмжлэг

2015 онд Казакстан тэргүүлэх хөрөнгө оруулалтын төслийн хөрөнгө оруулагчдад зориулж нэг цэгийн үйлчилгээг туршилтаар нэвтрүүлсэн. Туршилт амжилттай болсон тул 2016 онд нэг цэгийн үйлчилгээг өргөжүүлэн бүх хөрөнгө оруулагчдад хүртээмжтэй байхаар шийдвэрлэсэн ба бүх мужид нэвтрүүлэхээр ажиллаж байна. Хөрөнгө оруулагчдад зориулсан нэг цэгийн үйлчилгээгээр төрийн үйлчилгээний талаарх зөвлөгөө мэдээлэл хүргэх, төрийн үйлчилгээг авахад шаардлагатай бичиг баримтыг бэлтгэхэд туслах, цахим гарын үсэг, онлайн өргөдөл, бусад баримт бичиг авахад туслах, холбогдох үйлчилгээг эрх бүхий байгууллагаар дамжуулан авахад хөрөнгө оруулагчдад туслах зэрэг үйлчилгээг үзүүлдэг. Эдгээр үйлчилгээ нь бүгд Казахстаны Аж ахуйн нэгжийн тухай хуульд заасны дагуу хийгдэж байгаа бөгөөд хөрөнгө оруулагчдад зориулсан “Нэг цэгийн үйлчилгээ”-ний журмыг 2015 онд баталжээ.

Маргаан шийдвэрлэлт

2018 оны 1-р сард Астанагийн Олон Улсын Санхүүгийн Төв (АОУСТ) нээгдсэнээр Английн хуульд суурилсан, гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан тусгай шүүх байгуулсан. Энэ нь хувийн бизнес эрхлэгчдэд гэхээсээ засгийн газарт давуу эрх олгодог шүүхийн нөлөөг бууруулна гэж үзэж байна. Уг тусгай шүүх нь бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчдын гол санаа зовдог шүүхийн байгууллагын ил тод, эрх тэгш шударга байдлыг нэмэгдүүлэх зорилготой. Мөн Казахстаны эрх баригчид маргааныг арбитр, эвлэрүүлэн зуучлалаар шийдэх сонирхлыг дэмжиж иржээ. Маргаан шийдвэрлэх эдгээр механизм нь Казахстаны шүүхийн ачааллыг бууруулж, шүүхийн тогтолцоонд дэмжлэг болно гэж үздэг.

1.3. Перу

Өнөөгийн Перу улс 16-19-р зуунд Испанийн колони байсан. 1810-аад онд Испанийн бусад колони улс тусгаар тогтнолоо олж авсан бол Перу Испанид үнэнч хэвээр үлдэж байв. Гэхдээ эцэстээ Перу гадаадын оролцоотойгоор тусгаар тогтножээ. Колонийн хамаарлаас гарч бие даасан улс болох шилжилт амаргүй байсан бөгөөд хуулийн системээ маш олон удаа сольсон. 1930 онд Перу ардчилсан тогтолцооноос дарангуйлал руу шилжиж, дараа нь сонгуульт төр, дараа нь цэргийн засаглалтай болж, тогтолцооны хэлбэрээ сольж явсаар эцэстээ олон намын тогтолцоотой, ерөнхийлөгчийн засаглалтай улс болжээ. Перугийн армийн хийсэн төрийн эргэлтүүд, үндсэн хуулийн өөрчлөлтүүд эдийн засгийн хөгжилд саяхныг хүртэл сөрөг нөлөөлж ирсэн.

Перугийн хөдөө аж ахуй салбар нь түүхэндээ ажиллах хүч, үйлдвэрлэлийн ихэнхийг хангадаг эдийн засгийн гол салбар байжээ. Гэвч сүүлийн 20 гаруй жилд эдийн засгийн төрөлжилт явагдаж, тус улс зэс, мөнгө, хар тугалга, цайр, алт, төмрийн хүдэр, байгалийн хийн олборлолтоор дэлхийн тэргүүлэх орнуудын нэг болсон. Ингэснээр уул уурхай, үйлчилгээний салбар эдийн засгийн гол салбарууд болжээ. Мөн сүүлийн жилүүдийн эдийн засгийн өсөлтөд уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтын өсөлт чухал нөлөө үзүүлжээ.

2013 онд ДХБ-аас нийтэлсэн Перугийн Худалдааны бодлогын тоймд дурдсанаар, гадаадын хөрөнгө оруулагчид дотоодын хөрөнгө оруулагчидтай ижил хууль эрхзүйн үйлчилгээ авдаг. Гэхдээ далайн үйлчилгээ, агаарын тээвэр, өргөн нэвтрүүлэгт зарим хязгаарлалт тавьдаг. Түүнчлэн Перугийн засгийн газар дэд бүтэц барих төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд оролцуулах, татварын хөнгөлөлт болон өртөг багатай санхүүжилт санал болгохдоо дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдад адил боломж олгодог (World Trade Organization, 2013).

Перу улс хувийн хөрөнгө оруулалтыг дэмжихийн тулд дотоод, гадаад хөрөнгө оруулагчдад хууль, татварын тогтвортой байдлын гэрээ санал болгодог. Энэ гэрээгээр хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан хууль, татварын дэглэм 10 жилийн турш тухайн хөрөнгө оруулалтын хувьд өөрчлөгдөхгүй. Хөрөнгө оруулалтын тогтворжуулалтын гэрээ байгуулахын тулд уул уурхайн салбарт оруулсан хөрөнгө оруулалтын дүн 10 сая доллароос, бусад салбарт 5 сая доллароос дээш байх ёстой. Мөн хувьчлалаар компанийн хувьцааны 50-аас дээш хувийг худалдаж авахдаа компанийн суурилагдсан хүчин чадлыг өргөтгөх, эсвэл технологийг шинэчлэх нөхцөлтэй бол тогтворжуулалтын гэрээ байгуулж болно.

1991 онд Перу улс өргөн хүрээтэй хувьчлалын хөтөлбөр эхлүүлсэн боловч одоогоор хэрэгжүүлж дуусаагүй байна. Томоохон төслүүдэд хөрөнгө оруулалт татахын тулд олон жилийн концессыг дэмждэг боловч эдгээр төслийн тендерт гадаадын компани оролцоход бэрхшээл ихтэй байдаг (U.S. Department of State, 2018). Хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр ажилладаг Проинвершн гэх засгийн газрын агентлаг сүүлийн жилүүдэд тендер шалгаруулах явц, хугацаа, бодитой биш ажлын хуваарийн талаар нэлээд шүүмжлэлд өртөж байна. Иймээс гадаадын хөрөнгө оруулагчдын ихэнх нь концессын төслүүдэд оролцох сонирхолгүй болжээ.

Перугийн хууль эрх зүйн орчин олон улсын хөрөнгө оруулалтыг дэмждэг бөгөөд хоёр талын болон чөлөөт худалдааны хэлэлцээрт нэгдсэн (UNCTAD, 2018). Перугийн хууль эрх зүйн тогтолцоо гэрээний тогтвортой байдлыг хангаж, дотоодын болон олон улсын хөрөнгө оруулалтыг дэмждэг. Гэсэн хэдий ч ихэнх хөгжиж буй орны адилаар авлига өргөн тархсан тул гэрээний хэрэгжилт, шүүхийн шийдвэрийн биелэлт тааруу байна. Шүүхийг шинэчлэх удаа дараагийн оролдлогууд амжилтгүй болсон учир ойрын хугацаанд шүүхийн шинэчлэл гол сэдэв хэвээр байх төлөвтэй байна.

Өмнөх ерөнхийлөгч Педро Куцински авлигыг устгана гэж амласан ч өөрөө авлигын хэргээр огцорсон. Иймээс одоогийн ерөнхийлөгч Мартин Вицкарагийн удирдлага дор Перу улс олон нийт болон хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх дорвитой арга хэмжээ авах хэрэгтэй байна. Гадаадын хөрөнгө оруулагчдын эргэлзээг төрүүлдэг бас нэг зүйл бол тус улсын хууль болон түүний хэрэгжилтийн уялдаагүй байдал юм (U.S. Department of State, 2018).

1.4. Замби

Замби улс 1964 онд Их Британиас тусгаар тогтножээ. 1973 онд нэг намын засаглалтай болсноор Замби улс анхны үндсэн хуулиа орхижээ. Гэвч олон удаагийн бослого тэмцэл, төрийн эргэлт хийх оролдлогын дараа 1991 онд үндсэн хуулиа эргэн сэргээж, олон намын тогтолцоотой болсон. Улмаар 1991 оны сонгуулийн дараа анхны ерөнхийлөгч Кеннет Каунда албан тушаалаа орхижээ.

Одоогоор Замби улс 2015-2016 оны зэсийн үнийн бууралт, усан цахилгаан станцын алдаатай менежментээс үүдсэн эрчим хүчний хомсдол болон үндэсний валютын ханш уналт зэргээс шалтгаалсан эдийн засгийн хямралаас дөнгөж гарч байна. 2017 онд зэсийн үнэ огцом өссөний дүнд эдийн засаг бага зэрэг өсжээ. Замби улс колонийн үеэсээ буюу Британийн Өмнөд Африкийн Компани гэх компани зэс олборлодог байх үеэс зэсийн экспортоос хамааралтай байсан. Өнөөдөр ч эдийн засгийн гол хөдөлгөгч хүч, ГШХО-ыг татах гол салбар нь уул уурхай хэвээр байна.

Замби улс хөрөнгө оруулалт татахын тулд Хувийн салбарын хөгжлийн шинэчлэлийн хөтөлбөр болон Мянганы Сорилын Сангаар дамжуулан бизнес эрхлэлт, ил тод байдал, засаглалд тулгарч буй бэрхшээлийг арилгах институцийн шинэчлэлүүд хийсэн. Гэвч шинэчлэлийн процесс үр ашиггүй, сунжирсан тул анх зорьсон үр дүнд хүрээгүй. Замби улсын шүүхийн процесс удаан, хэргийг шийдэлгүй удаадаг. Дэлхийн Банкны “Бизнес эрхлэхүй 2019” тайланд дурдсанаар, гэрээний хэрэгжилтийг хангуулахад 611 хоног зарцуулдаг. Засгийн газрууд нь уул уурхай, харилцаа холбоо, банкны салбарт өмнөх засгийн газруудын байгуулсан олон гэрээг цуцалж,

дахин хэлэлцээр хийжээ. Зарим хөрөнгө оруулагч үүнийг хувийн өмчийг нийгэмчлэх оролдлого гэж үздэг бол өмнөх ерөнхийлөгч Майкл Сата үүнийг үгүйсгэж, төр ийм бодлого баримтлаагүй гэж мэдэгдсэн. Гэвч засгийн газар уул уурхайн татварыг эргэн харах, роялтиг нэмэгдүүлэх, хувийн хэвшилд газар эзэмшүүлэх эрхийг хязгаарлах, үр тарианы экспортыг хязгаарлах зэрэг мэдэгдэл удаа дараа хийдэг нь гадаадын хөрөнгө оруулагчдад тодорхойгүй байдал үүсгэж байна.

Замбийн Хөгжлийн Агентлагийн хуулиар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын олон янзын хөнгөлөлт санал болгодог. Орлогын татварын хууль болон Гаалийн албан татварын хуульд, 500,000 ам.доллараас дээш хөрөнгө оруулалтыг эдийн засгийн чөлөөт бүс, аж үйлдвэрийн парк, тэргүүлэх салбарт, эсвэл хөдөө орон нутгийн аж ахуйн нэгжид хөрөнгө оруулбал доорх санхүүгийн урамшуулал үзүүлэхээр заажээ. Үүнд:

- Үйл ажиллагаа эхэлснээс хойш 5 жилийн хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх.
- Үйл ажиллагаа эхэлснээс хойш 6-8 дахь жилд компанийн ашгийн 50 хувьд, 9-10 дахь жилд ашгийн 75 хувьд нь л татвар ноогдуулна.
- Ноогдол ашиг зарлаж эхэлснээс хойш эхний 5 жилд ноогдол ашгийн татвараас чөлөөлнө.
- Импортоор оруулж ирсэн машин, тоног төхөөрөмжийг 5 жилийн хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлнө.
- Дэд бүтцийг сайжруулах, шинэчлэхэд зарцуулсан хөрөнгийн зардлыг 100 хувь татвар ноогдуулах орлогоос хасна.

Аль ч салбарт 250,000 ам.доллараас дээш хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулагч дээрх хөнгөлөлтийг эдлэхээс гадна цагаачлалын зөвшөөрөл, хоёрдогч лиценз, газар эзэмших эрх болон ус, цахилгаанд үнэгүй холбогдох, төр тусгай зөвшөөрлийг хураахгүй гэсэн хөрөнгө оруулалтын баталгаа гаргуулж авахаар заасан. Харин 10 сая ам.доллараас дээш дүнтэй хөрөнгө оруулалтад сангийн сайд тусгайлсан нэмэлт хөнгөлөлт олгох эрхтэй.


Тус улсын Сангийн сайд 2018 оны улсын төсвийг танилцуулахдаа орлогын албан татвараас 5 жил чөлөөлөх заалтын оронд хөрөнгийн элэгдлийн зардлыг хурдасгасан аргаар тооцох саналыг дэвшүүлсэн. Татварын чөлөөлөлт нь төсвийн орлогод сөргөөр нөлөөлөх байсан тул энэ саналыг дэвшүүлжээ. Гэвч уг санал гадаадын хөрөнгө оруулагчдын шүүмжлэлтэй тулгарч, зарим хөрөнгө оруулагч тус улсад нэмж хөрөнгө оруулахаа зогсооно гэж мэдэгдсэн. Энэ санал хараахан батлагдаагүй байгаа боловч хэрэгжиж эхэлбэл гадаадын хөрөнгө оруулалтад сөрөг нөлөөлөх нь гарцаагүй юм.

1.5 Бизнес эрхлэхүй-2019

Дэлхийн банкны *Бизнес эрхлэхүй* судалгаа нь бизнесийн 11 хүрээний зохицуулалтыг үнэлдэг. Энэ жилийн хувьд бизнес эхлүүлэх, тусгай зөвшөөрөл шинээр авах, цахилгаан хангамжид холбогдох, үл хөдлөх хөрөнгө бүртгүүлэх, зээл авах, цөөнх хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах, татвар төлөх, хил дамнасан худалдаа хийх, гэрээний хэрэгжилтийг хангах, дампуурлыг шийдэх зэрэг 10 асуудлаар үнэлгээ хийсэн. Харин хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг энэ жил үнэлээгүй.

Монгол Улсын хувьд жагсаалтад 62-р байраас ухарч 74-т бичигдээд байна. Монгол Улсын хувьд багахан өссөн үзүүлэлттэй байв. Энэ нь хэрэгжих ёстой байсан гэрээ, төслүүдийн үйл явцыг түргэтгэсэнтэй холбоотой. Гэрээний шинэчлэлийг хэрэгжүүлж байгаа хэдий ч 128 улс 2017 оны 6-р сарын 2-оос 2018 оны 5-р сарын 1-ний хооронд хийсэн 314 зохицуулалтыг шинэчлэн сайжруулж, Монгол Улс чансаагаараа буурав.

Зураг 3. Бизнес Эрхлэхүй - 2019



Source: World Bank

Дэлхийн Банкны Бизнес Эрхлэлт 2019 оны тайланд Казахстан улс нийт 190 улсаас 36-р байрт орж 28-р байрнаас дээшилсэн. 8 байраар дээшилсэн нь доорх 3 салбарт үзүүлэлтээ сайжруулсны үр дүнд байв. Үүнд гэрээний биелэлтийг бүрэн хангуулсан, хилийн арилжааг хийх арга хэмжээг хэрэгжүүлсэн зэрэг багтана.

Түүнчлэн Казахстан улс нэмэгдсэн өртгийн албан татварын бүртгэлд бүртгүүлэх хугацааг багасгаснаар шинээр бизнес эхлүүлэхэд таатай орчин бүрдүүлж өгсөн. Гэрээний биелэлтийг хялбарчлах үүднээс Казахстан улс арилжааны хэргийн талаар гаргасан шийдвэрийг олон нийтэд нээлттэй зарлаж, гүйцэтгэлийн хэмжилтийн тайланг орон нутгийн арилжааны шүүхэд гаргаж байсан. Казахстан улс гаалийн мэдүүлгийн системийг цахим хэлбэрт оруулснаар хилийн орчим худалдаа арилжаа эрхлэх үйл явц сайжирсан. Мөн АСТАНА-1 IS болон гаалийн захиргааны хураамжийг өнгөрсөн жил буруулсан байна.


Перу улсын хувьд өмнө жил 58-р байранд жагсаж байсан бол энэ жил 68-р байранд орсон. Гэхдээ энэ өөрчлөлт нь хууль дүрэм сайн сахиж биелүүлсэн ч бусад улс орнууд илүү сайжирсны үр дүнд гарсан гэж дүгнэх боломжтой. 2 салбар нэлээд сайжирсан үзүүлэлттэй гарсан. Үүнд шинээр бизнес эхлүүлэх мөн барилгын тусгай зөвшөөрөл авах ажлууд багтсан байна. Түүнчлэн хотын захиргаанаас лиценз авахад зарцуулах цаг хугацаа, холбогдох дүүргийн засаг захиргааны байшин барилгын аюулгүй байдлын техникийн үзлэгт зарцуулагдах цаг хугацаа зэрэг нь үлэмж багассан байна. Перу улсын хувьд барилгын чанарын хяналтыг сайжруулах боломж нээгдсэн төдийгүй техникийн үзлэг хийдэг мэргэжилтнүүдэд тавих ур чадварыг шаардлагуудыг өндөржүүлснээр барилгын чанарын хяналтад тавьдаг хяналтыг сайжруулах боломж гарсан байна.

Монгол, Перу улсуудын адил Замби улс жагсаалтад эрэмбээр буурчээ. 87-р байрнаас 85-д жагсах болсон. Хэдийгээр 10-н салбарт сайжралт гарсан ч 87-р байрнаас 85-д эрэмбэлэгдэв. Замби улсын хувьд энэ жил гэрээ, хэлэлцээрийн биелэлтийг сайжруулахад нэлээдгүй арга хэмжээ авч хэрэгжүүлсэн ба арилжааны шинж чанартай маргаан хэрэгт үндэслэл оруулж ирснээр дээд шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд цахимаар явуулах болсон зэрэг дэвшил гарсан байна. Замби улс энэ жилийн хувьд гэрээний биелэлт, хэрэгжилтийг нэлээд түргэсгэх, арилжааны хэргүүд болон хэд хэдэн төслүүд дээр холбогдох арга хэжээг авах, сонсголыг олон нийтэд ил болгох зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөсөн байна.

1.5. Авлигын төсөөллийн индекс

2018 оны Авлигын төсөөллийн индексийн тайлангаас харахад улс орнуудын авлига бууруулах тал дээр авсан арга хэмжээ хангалтгүй байна гэж дүгнэжээ. Дийлэнх улс орнууд буюу 2/3 нь 50-с доогуур оноо авсан байна.

Зураг 4. Авлигын төсөөллийн индекс 2018 Зураглал



Source: Transparency International

2018 онд Монгол улсын хувьд Авлигын төсөөллийн индекс сайжирч, 103-р байрнаас 93-т жагссан. Авлигын эсрэг хуулийн дагуу албан тушаалтан авлига авсан нь тогтоогдсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. Тус хуулийн хэрэгжилт харьцангуй муу байгаа тул авлигын индексийн хэмжээ буурахгүй байгаа болно. Монгол улсын хувьд авлигын эсрэг хууль тогтоомжийг 2017 оны 1-р сард баталж, тус хууль нь авлигатай хатуу тэмцэх, авлигатай холбоотой гэмт хэргүүдэд холбогдсон төрийн албан хаагч, Засгийн газрын гишүүдэд өндөр хариуцлага тооцохоор заасан байна.

Түүнчлэн 2017 оны 3-р сард, Засгийн газар 3 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөр нь 2016 оны 11 сард батлагдсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд авлигын эсрэг хуульд хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт оруулж байсан.

Түүнчлэн 2017 оны 3-р сард, Авлигатай Тэмцэх Үндэсний Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор засгийн газар 3 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулсан. Сүүлийн хэдэн жилийн хугацаанд авлигатай тэмцэх хуульд хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт оруулсан. Мөн төрийн бус байгууллагыг хамгаалах хууль өнөөдрийг хүртэл батлагдаагүй байгаа. Гэхдээ Засгийн газрын авлигатай холбоотой хэргүүдийг олж илрүүлэн мэдээлсээр байгаа билээ. 2017 оны 7-р сараас хойш авч хэрэгжүүлсэн өөр нэг арга хэмжээ бол авлигатай тэмцэх зорилгоор оффшор банкны дансны хэрэглээг багасгах. Үүнтэй холбоотойгоор, Авлигатай Тэмцэх Газраас 2018 оны эхээр хэд хэдэн төрийн албан хаагчид оффшор банканд данстай байсан ба заавал хяналт шалгалт хийлгэх шаардлагатай гэж үзсэн байна.

Казахстан улсын хувьд бусад улс орнуудын адил авлига нэлээд тархсан. 2018 онд Казахстан улсын Авлигын индексийн оноо 100-аас 31 байсан бөгөөд 180 улсаас 124-т эрэмбэлэгдэж байв. 31 гэдэг нь харьцангуй сул оноо юм. Хэдийгээр Казахстан Улсын эрэмбэ огцом буурсан ч оноо хэвээр үлдсэн. Казахстан Улсын эрэмбэ бусад 3 улстай харьцуулахад доогуур түвшинд хэвээр

байна. Авлигын асуудал Казахстаны хувьд томоохон хүндрэл бэрхшээлтэй асуудлын нэг байгаа ба гадаадын хөрөнгө оруулагчдын анхаарлыг татсан асуудал хэвээр байна. 2014 оны 12-р сарын 26-ны өдөр, Казахстан улсын Ерөнхийлөгч Назарбаев 2015-2025 онуудыг хамарсан авлигын эсрэг стратеги, хуулийг баталсан. Энэхүү хууль тогтоомж нь авлигын эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан байна.

2015 онд “Авлигатай тэмцэх арга хэрэгсэл” хууль Казахстан улсын ерөнхийлөгч Назарбаевын “Бүтцийн өөрчлөлт, шинэчлэлийн 5 хөтөлбөр”-ийн нэг хэсэг болон батлагдсан. Үүнд авлигын тухай илүү дэлгэрэнгүй тодорхойлолт, авлигын бодлого, эрсдэл, авлигын эсрэг үйл ажиллагааны хяналт, шинжилгээ, санхүүгийн илүү хариуцлагатай байдлыг нэвтрүүлж тусгасан болно.

Стратеги, хөтөлбөрөөс гадна, шинэ эрүүгийн хуулийг 2015 оны 1-р сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн ба авлига авсан тохиолдолд зохих шийтгэлийг хүлээлгэх үүднээс эрүүгийн хариуцлагыг чангатгасан. Шинэ эрүүгийн хуулийн хүрээнд авлига авсан тохиолдолд төрийн албанд ажиллах эрхийг бүх насаар нь түдгэлзүүлдэг. Мөн энэ нь эрхэлж байгаа албан тушаалын зэрэг, шагнал алинаас ч үл хамаарна. Эдгээр хууль эрх зүй болон бүтцийн шинэчлэлтээс үл хамааран, авлига нь гадаадын хөрөнгө оруулалтыг татахад саад тотгор болсоор байна.

Хүснэгт 1. Авлигын төсөөллийн индекс 2018

		Монгол	Казахстан	Перу	Замби
Эрэмбэ	2018 (180 орноос)	93	124	105	105
	2017 (180 орноос)	103	122	96	96
	2016 (176 орноос)	87	131	101	87
Оноо	2018	37	31	35	35
	2017	36	31	37	37
	2016	38	29	35	38

Эх сурвалж: Transparency International

Авлигын асуудал нь хөгжиж байгаа, бага болон дунд орлоготой улс орнуудын хувьд үндсэн саад бэрхшээл хэвээр үлдсэн. Перу Улсын хувьд Авлигын Төсөөллийн Индекс 2018 онд нэлээд буурч, 9 байр ухарсан. Авлигатай холбоотой хамгийн томд тооцогддог хэрэг 2016 оны 12-р сард гарсан. Бразил компани болох Odebrecht нь АНУ, Бразил, Швейцар улсуудад зарга үүсгэсэн. Шүүхээр маргаан шийдвэрлэх болсон шалтгаан нь Перу улсад 29 сая ам.долларын хахууль өгсөн хэрэг байсан. Энэ нь өмнөх ерөнхийлөгч Alejandra Toledo-г баривчлах баривчилгааны шалтгаан болсон. Odebrecht компаниас Toledo-г хахуульд 20 сая ам.доллар авсан хэрэгт сэжиглэн Далайн хоорондын хурдны зам төслийн ажлыг түргэвчлэх хэрэгт нөлөөлсөн байж болзошгүй гэсэн шалтгаанаар сэжиглэн хэрэг үүсгэсэн байна.

Перу улсын хувьд, төрийн албан хаагч нь өөрийн ажил үүргээ гүйцэтгэсний төлөө хээл хахууль авах нь хуулиар хатуу хориотой байдаг нь Монгол улстай ижилхэн. Түүнчлэн авлигатай холбоотой хууль тогтоомжууд 2017 оны 3 сард батлагдсан ба ашиг сонирхлын зөрчлийг арилгах зорилгоор гаргасан болно.

Замби улсын хувьд Авлигын төсөөллийн индекс 2 оноогоор буурч, 2017 онд 96, 2018 онд 105-р байранд орсон байна. Замби улс сүүлийн 10 жилд авлигатай тэмцэхэд тодорхой ахиц дэвшил гаргасан. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд авлигын төсөөлөл нэмэгдсэн нь Авлигын төсөөллийн индексээр сүүлийн хоёр жилийн дотор 18 байраар ухрахад хүргэжээ. Хүнд суртлыг арилгах, авлигын өнөөгийн түвшнийг бууруулах, авлига авсан хэргүүдийг шалгах тэр дундаа өндөр алба тушаалтан оролцсон хэргийг шалгах тал дээр нэлээдгүй хүчин чармайлтуудыг гаргасан байдаг. Харамсалтай нь авлига авсан нь тогтоогдсон хэдий ч албан тушаалаасаа огцроогүй хэргүүд олноор бүртгэгдсэн. Замби Улсын засгийн газраас хувийн хэвшлийн компаниудыг төрийн албан тушаалтнуудад хээл хахууль өгөхийг хориглосон дотоод ёс зүйн дүрмийг бий болгохыг уриалж байна.

2. Олборлох үйлдвэрлэл дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт

Олборлох үйлдвэрлэл Монгол, Казахстан, Перу, Замби улсын эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, ГШХО-ыг шууд утгаар нэмэгдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой. Энэ бүлэгт, улс тус бүрийн ГШХО-ыг оруулалтыг хэрхэн дэмжиж, нэвтрүүлж байгаа талаар судалсан.

2.1. Монгол улс

Өмнөх бүлэгт дурдсанчлан, Монгол улсын хувьд ГШХО-ын үндсэн эх үүсвэр нь Оюу Толгой төсөл билээ. Бусад салбаруудын хувьд уул уурхайн салбарт хөрөнгө оруулагчдын дэд бүтцэд оруулж байгаа шууд бус хөрөнгө оруулалтаас үр өгөөж хүртэх боломжтой.

2018 онд нийт ГШХО-ын 90 орчим хувь нь Оюу Толгой зэрэг уул уурхайн томоохон төслүүд дээр төвлөрч байсан (Byambasuren, 2019). 2018 оны 12-р сарын байдлаар Монгол Улсын ГШХО-ын хэмжээ 1.8 тэрбум ам.доллар байв. Энэ нь 2017 оны мөн үетэй харьцуулахад 422 сая ам.доллараар өссөн байна (Bank of Mongolia, 2018). Сангийн яамны мэдээлснээр Оюу Толгой төслийн хөрөнгө оруулалт 2019 онд 1.3 тэрбум ам.долларт хүрэх тооцоотой байна.

Өмнөх бүлэгт дурдсанчлан, татварын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь уул уурхайн салбарын хувьд шууд бус шилжүүлгийн татвар зэрэгт томоохон үр нөлөөтэй байх болно. Доорх өөрчлөлтүүдийг газар эзэмших эрх, хайгуулын ба уул уурхайн лицензийн татварын хувьд оруулсан болно. Үүнд:

- Татварын шинэчилсэн хуулийн дагуу газар эзэмших эрх, хайгуулын болон уул уурхайн лицензийг шилжүүлэхэд үндсэн дүнгийн 30 хувьд татвар оногдуулахаар заасан байна.
- Шилжүүлсэн эрхийн татвар ногдуулах дүнг тодорхойлох цогц аргачлалыг нэвтрүүлж, татварын албанд гэрээний дүнг харьцуулж, тохируулах эрх олгосон.
- Лицензийн эрх эзэмшиж байгаа компаниудын хувьд лицензийн үндсэн эзэмшигчийн нэр, бүртгэлийг Улсын Бүртгэлийн ерөнхий газарт 2018 оны 6-р сарын 1-с өмнө бүртгүүлэх ёстой.
- Үндсэн өмчлөх эрхэд өөрчлөлт орсон тохиолдолд хуулийн дагуу холбогдох байгууллагад мэдэгдэж бүртгэлийг хийлгэнэ.
- Шинэ дүрмийг дагаж мөрдөөгүй тохиолдолд төрийн эрх бүхий байгууллагууд зөвшөөрлийг нь цуцлах эрхтэй.

Лиценз, газар эзэмших эрхийг шууд шилжүүлэх нь тухайн эзэмшигч өмчлөх эрхийг дамжуулж байна гэж ойлгож болно. Хууль эрх зүйн дагуу өмчлөгч гэсэн ухагдахууныг илүү өргөн нэр томъёогоор тодорхойлбол тухайн өмч хөрөнгийг удирдах, хяналтад нь оролцох эрх бүхий этгээд гэж тодорхойлж болно.

- Эрх эзэмшигч нь санал өгөх эрхийн нэлээдгүй хувийг эзэмшдэг.
- Компанийн нэлээд их хэмжээний хувьцааг эзэмшдэг.
- Эзэмшигч нь дээр дурдсантай ижил төстэй өөр бусад эрхийг эдэлнэ.

Шинэ татварын хуулийн нэмэлт өөрчлөлт нь гадаадын хөрөнгө оруулагчид, тэр дундаа хайгуулын болон олборлолтын лиценз эзэмшигчдийн хувьд чухал асуудлуудын нэг юм. Иймд доорх бүлэгт холбогдох нэмэлт мэдээллийг дэлгэрэнгүй дурдах ба тэдгээрийн үүсэж болзошгүй нөлөөг авч үзэх болно. Олборлолтын лицензийг шилжүүлэхтэй холбоотой татварын суурь дүнг худалдан авагч тал болон лицензийг зарж байгаа талын гэрээний үнэнд суурилна.

Хайгуулын лицензийг шилжүүлэхтэй холбоотой татварын асуудал нь худалдан авагч тал борлуулагч талуудын харилцан тохиролцсон гэрээний үнийн дүнгээс шууд шалтгаална. Хэрэв гэрээний дүн нь шууд бус хоёр аргыг ашиглан тодорхойлсон утгаас 20 хувь буюу түүнээс их хувиар бага байвал шууд бус үнэлгээний аргаар тодорхойлсон үнээр сольж болно. Гэхдээ энэ тохиолдолд татвар ноогдуулах дүн нь харьцуулсан жишиг буюу өртөгт суурилсан хоёр шууд бус аргын аль бага утга нь байна.

Ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлэхэд татвар ногдуулах суурь дүнг тодорхойлох нь зарим тохиолдлоос бусад үед хайгуулын тусгай зөвшөөрөлтэй төстэй байдаг. Ашиглагддаг бас нэг арга бол өнөөгийн цэвэр үнэ цэнэ (NPV) дээр суурилсан арга юм. Тухайн уул уурхайн төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнийг Монгол Улсын Ашигт малтмал, газрын тосны газар(АМГТГ)-т ирүүлсэн ТЭЗҮ-ээс харж болох юм.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл шилжүүлэх тохиолдолд татвар ногдуулах хэмжээг тодорхойлох одоогийн цэвэр үнэ цэнд суурилсан аргаар тооцоход уул уурхайн төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ 30 хувийн татварыг эрсдэлд оруулж болзошгүй. Мөн хөрөнгө оруулагчид татварын өндөр өртгийг үндэслэлгүй гэж үзэж болох юм. 30 хувийн татварын хувь хэмжээ нь татвараас зайлсхийх асуудлыг шийдвэрлэхээс илүү гадаадын хөрөнгө оруулагчдад хохирол учруулах эрсдэлтэй. Гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд татварын таатай орчин, үр өгөөжийг хамгийн том хөшүүрэг гэж үздэг. Түүнчлэн Оюу Толгойн 2009 оны Хөрөнгө оруулалтын гэрээн дэх тогтворжуулалтын заалтын дагуу татварын энэ нэмэлт өөрчлөлтөөс чөлөөлөх талаар тусгажээ.

2.2. Казахстан

Хуучнаар Зөвлөлт Холбоот Улс задарсны дараа, газрын тосны салбар нь ГШХО-г татах гол салбар нь байсан. Доорх тоон үзүүлэлтийг ажиглавал, Казахстан улс дахь ГШХО-ын орох урсгал газрын тосны үнийн хөдөлгөөнтэй ихээхэн хамааралтай байна. 2016 оны газрын тосны үнийн уналтын үед ГШХО-ын өсөлт 36.8 тэрбум ам.доллартой тэнцэж байсан нь Tengiz field төслийн өргөтгөлийн ажил, Chevron ба түүний түншүүд санхүүжүүлсэн Future Growth Project – Wellhead Pressure Management Project зэрэг төслүүдэд оруулсан хөрөнгө оруулалт байжээ. Tengiz field төсөл нь дэлхийн хамгийн том нефтийн төслүүдийн нэг ба Казакстаны газрын тосны үйлдвэрлэлийн 3 хувийг бүрдүүлдэг.

Энэхүү өргөтгөлийн ажил нь 2016 онд хийгдсэн хамгийн том хөрөнгө оруулалт бөгөөд сүүлийн жилүүдэд хэрэгжсэн томоохон 3 төслийн нэг юм. Удаах 2 төсөл нь Statoil's Johan Sverdrup болон Shell's Appomatox байв.

Зураг 5. Казахстан улс дахь ГШХО, газрын тосны үнэ, 2000-2017



Хөрөнгө оруулалт хийгдсэн жагсаалтаас харвал, олборлох үйлдвэрлэл нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах үндсэн салбар хэвээр байна. Казахстан улсын хууль эрх зүйн шинэчлэлийг судалж үзэхэд зарим заалтууд нь олборлох үйлдвэрлэлд тусгайлан зориулагдсан болох нь харагдаж байна. Казахстан Улсын 2010 оны Гадаргуу болон түүний хэвлий дэх байгалийн баялгийг ашиглах хуулийн 30-р заалтын дагуу олборлох үйлдвэрлэлийн хөрөнгө оруулагч нарт өөрийн эрх ашгийг хамгаалах эрхийг олгодог. Гэхдээ хууль тогтоомжид орж байгаа зарим нэг заалтууд аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Эдгээр харин өөрчлөлт хийгдэхээс өмнө байгуулсан гэрээнд нөлөөлөхгүй. Түүнчлэн Засгийн газрын зүгээс Гадаргуу болон түүний хэвлий дахь байгалийн баялгийг ашиглах хуулийг шинэчлэн, Уул уурхайн баялгийн хуулийг өргөн барихаар болжээ.

Шинэ Уул уурхайн хууль нь 2018 оны 6-р сард хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн. Тус хууль нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах зорилготой ба лиценз эзэмшигчдийн хувьд харьцангуй уян хатан нөхцөлийг санал болгосон байна. Албан ёсны мэдээллийн дагуу, Казахстан улсын батлагдсан металл түүхий эдийн байгалийн баялгийн орд газрын нөөцийн зөвхөн 15 хувьд олборлолт хийгдсэн. Байгалын баялгийг бүрэн гүйцэд ашиглаж чадахгүй байгаа нь тус улсын хууль эрх зүйн системтэй холбоотой. Засгийн газрын хүнд суртал, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үүнд бас нөлөөтэй гэж дүгнэсэн байна. Гадаргуу болон түүний хэвлий дахь байгалийн баялгийг ашиглах зөвшөөрөл олголт журамд гарсан зарим өөрчлөлтүүд нь Засгийн газрын уул уурхайн салбарыг дэмжих оролдлогын нэг хэсэг юм. Уул уурхайн компаниудын анхаарлыг хамгийн их татаж буй зүйл бол газрын хэвлийн нөөцийг ашиглах тухай хуульд заасан байгаль орчин, татвараас зайлсхийсэн, эсвэл стратегийн ач холбогдолтой тодорхой ордыг ашиглаж байгаа тохиолдолд уул уурхайн аливаа гэрээг төрөөс хянан үзэх боломжийг олгодог заалт юм.

Олборлох үйлдвэрлэлийг төрөлжүүлэх асуудал мөн л хэрэгжүүлэх шаардлагатай асуудлуудын нэг хэвээр байна. Жишээ нь Казахстаны олборлох үйлдвэрлэлийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийгдсэн хэд хэдэн гэрээнүүдэд “заавал мөрдөх шаардлагатай” дотоодын шаардлагууд гэж байдаг. Үүнд хөрөнгө оруулагч тал заавал дотоодын ажиллах хүчийг авч ажиллуулах, дотоодын бүтээгдэхүүнийг ашиглах гэсэн заалтууд орсон байдаг байна.

Гэхдээ энэхүү дотоодыг дэмжих бодлого нь хөрөнгө оруулагч компанийн үйл ажиллагаанд ихээхэн хүндрэл учруулж, Казахстан улсад бизнес эрхлэх нөхцөлийг хааж, зардлыг нэмэгдүүлж байгаа билээ. Харин тус улс ДХБ-д элсэн орсноор шинэ хууль тогтоомж батлуулж, одоо баримталж байгаа зарим нэг дүрэм журмыг мөрдөх шаардлагагүй болсон байна.

Өмнө нь гадаргуу болон түүний хэвлий дахь байгалийн баялгийг ашиглаж байгаа компани, хувь хүн Казахстан улсад үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, материал ашиглах шаардлагатай байсан. Харин одоо Казахстан улсад үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, материалыг заавал ашиглах шаардлагагүй болжээ.

2.3. Перу

Тус улсын ГШХО-ын дийлэнх хувь уул уурхай, харилцаа холбоо, санхүү, эрчим хүчний салбарт орж байна. Хөрөнгө оруулагчдыг татах үндсэн үзүүлэлтүүд нь ажиллах хүчний хөлс бага, ноогдол ашгийн бодлого харьцангуй хязгаарлалт багатай байдаг. Гэхдээ хөрөнгө оруулагчдын хувьд худалдааны саад бэрхшээл, төрийн байгууллагын үр ашиггүй байдал, хуулийн хэрэгжилт сул зэрэг асуудлууд ажиглагдсан хэвээр байна.

Уул уурхайн салбар нь экспортод ихээхэн нөлөөтэй хэдий ч ажлын байрыг төдийлөн нэмэгдүүлдэггүй. Үүнээс шалтгаалан уул уурхайн шинэ төслүүд байгаль орчин хамгаалах, газар

нутгаа хамгаалах хүчтэй эсэргүүцэлтэй тулгардаг. Зарим тохиолдолд эсэргүүцэл, жагсаал зохион байгуулагддаг. Энэ нь голдуу олборлох үйлдвэрлэлийн салбарт ажиглагддаг байна.

Гадаад эзэнтэй олборлох үйлдвэрийн төслүүд нь ихэнхдээ нийгмийн шүүмжлэл, тогтвортой бус байдал дагуулсан байдаг. Жишээ нь 2017 оны 8-р сард Loreto мужийн уугуул иргэд Канадын газрын тосны компанийн барилга байгууламж руу дайран эзлэхийг оролдсон байна. Энэхүү тэмцэл нь газрын тосны компанийг үйл ажиллагаандаа өөрчлөлт оруулахдаа орон нутгийн иргэдэд мэдэгдээгүй гэсэн шалтгаанаар зохион байгуулагдсан. Мөн 2017 оны 3-р сард Freeport McMoran-ийн эзэмшдэг Cerro Verde уурхайн ажилчид ажлын нөхцөл, цалин хөлсний хэмжээний улмаас бослого гаргасан байна.


Ихэнх тохиолдолд, эсэргүүцэгчид эсэргүүцлээ эрчимжүүлэхийн тулд төрийн бус байгууллагуудтай хамтардаг. Жишээ нь 2014 онд эдгээр зохион байгуулагчид, олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, усан цахилгаан станцын төсөл, алтны албан бус олборлолтод тавьсан хязгаарлалт, байгалийн хийн экспорт, засгийн газрын кокаиныг устгах бодлогыг эсэргүүцэн зам, нисэх онгоцны буудлыг хааж байсан. Зарим тохиолдолд эсэргүүцэл жагсаалын үеэр иргэд, цагдаагийн албан хаагч амь эрсдэх тохиолдол гардаг байна. 2018 оны 3-р сарын байдлаар Хүний эрхийг хамгаалах Ombudsman байгууллагад 136 эсэргүүцлийн жагсаал бүртгэгдсэн. Эдгээрийн 68 хувь нь олборлох үйлдвэрлэлтэй холбоотой байжээ.

Олборлох үйлдвэрлэлийн компаниудын эсрэг иргэний нийгмийн эсэргүүцэл зарим тохиолдолд томоохон хөрөнгө оруулалтыг зогсоох хэмжээнд хүргэдэг. Жишээ нь 2015 онд Areqüira хотод эсэргүүцэгчид Мексикийн эзэмшдэг Southern Cooper компанийн 1.4 тэрбум ам долларын Tia Maria зэсийн уурхайн хөрөнгө оруулалтыг хойшлуулжээ. Эдгээр асуудлуудыг зүй зохистой шийдвэрлэхийн тулд Засгийн газрын зүгээс Нийгмийн хөгжлийн сангаар дамжуулан боловсрол, дэд бүтэц, эрүүл мэндийн салбаруудад хөрөнгө оруулалтыг түлхүү хийхээр төлөвлөн ажиллахаар болжээ. Дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр засгийн газрын оролцоо нэмэгдэж, маргаан, зөрчил гарах магадлалыг бууруулна гэж үзжээ.

2.4. Замби улс

Байгалын баялагтай улс орнуудын адил Замби Улс зэс зэрэг эрдэст түүхий эдийн үнийн өсөлтөөс ашиг хүртэх боломжтой. 2002-2008 оны хооронд, Замби улсын эдийн засаг эрдэст түүхий эдийн үнийн өсөлтөөс шалтгаалан ихээхэн өсөлттэй байсан.

Зураг 6. Замби Улсын ГШХО, зэсийн үнэ, 2000-2017



Source: UNCTAD and World Bank

Эрдэст түүхий эдийн үнэ дэлхийн түвшинд буурсантай холбогдуулан 2014 оноос хойш АМНАТ-ын хуульд хэд хэдэн өөрчлөлтүүдийг оруулсан байна. АМНАТ-ын хэмжээний өөрчлөлт, бусад нэмэлт татварууд нь улс төрийн тогтворгүй байдалд хүргэсэн.

2015 оны 1-р сард татварын шинэчлэлд тусгагдсан аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг өөрчилж, АМНАТ-ын хэмжээг нэмэгдүүлсэн нь ихээхэн шүүмжлэл дагуулсан. 2015 оны 4-р сард хийсэн өөрчлөлтөөр АМНАТ-ыг бууруулж 9 хувь болсон. Үүний дараагаар тус оны 6-р сард хийгдсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр ил уурхайд 9 хувь, далд уурхайд 6 хувийн татвар оногдуулахаар болсон байна. Засгийн Газрын зүгээс АМНАТ-ын хуульд 2016 оны 5-р сард дахин өөрчлөлт оруулсан ба зэсийн үнэ унах, үйл ажиллагаа доголдох зэрэг эрсдэлүүд тулгарсан үед 4-6 хувийн АМНАТ-ыг ногдуулахаар болсон.

2019 оны Улсын төсөвт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 2 хувиар нэмэгдүүлж, 10 хувийн хязгаартай байх, импортын зэс кобальтын баяжмалд⁴ 5 хувийн татвар ногдуулах тухай тусгасан нь бодлогын хувьд нийцэхгүй байгааг онцлов. Тиймээс АМНАТ-ийг дараах байдлаар ногдуулахаар болжээ.

АМНАТ (%)	Зэсийн үнэ (ам.доллар/тн)
6	< 4,500
7	4,500 - 6,000
8	> 6,000
10	> 7,500


АМНАТ-ын тогтмол өөрчилж, татварын хувь хэмжээг нэмэгдүүлж байгаа нь Замби улсын Засгийн газрын гадаад өр төлбөрөө дарах оролдлоготой холбоотой. Түүнчлэн 2013 оны 2-р сард, Замби улсын Засгийн газар Chinese-run Collum Coal Mine-ийн жижиг хэмжээний уул уурхайн 3 төслийн ашиглах эрхийг цуцалсан байна. Цуцалсан шалтгааныг тодруулахад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа муу, эрүүл мэнд, байгаль орчныг доройтуулж байна гэж үзжээ. Гэхээ 2015 оны 4-р сард тус компанийн эрхийг сэргээжээ.

2.5. Хөрөнгө оруулалт татах индекс

Ихэнх тохиолдолд, хөрөнгө оруулалтын шийдвэрийн 40 хувь нь бодлогын хүчин зүйлээс шалтгаалдаг. Ашигт малтмалын эрх зүйн хүрээ потенциалын индекс нь улс орнуудын сайн туршлага дээр суурилдаг(дэлхийн жишигт нийцсэн зохицуулалтын орчин, өндөр өрсөлдөөнтэй татвар, улс төрийн тогтвортой байдал, уул уурхайн тогтвортой зохицуулалт). Дараах зурагт ашигт малтмалын потенциалын индексийг харуулав. Энэхүү индекст тухайн бүс нутаг хайгуулын хөрөнгө оруулалтыг дэмждэг бол шар, хөрөнгө оруулалтыг саатуулах хүчин зүйл байхгүй тохиолдолд цэнхэр өнгөөр тэмдэглэсэн. Индексийг цэнхэр өнгөөр авсан хүчин зүйл нь шар өнгийн хүчин зүйлийн хагаст байхаар жинлэн тооцдог.

⁴ Currently, copper imports feed large scale smelt and refinery operations in the Zambian economy.

Зураг 7. Ашигт малтмалын потенциалын индекс (MPI)



Source: Fraser Institute

Монгол, Казахстан, Перу улсын хувьд эрдэс баялгийн нөөцийн хэмжээ /потенциал/ 2016-2017 оны хооронд нэмэгдсэн. Үүнээс шалтгаалан эдгээр улс орнуудын ашигт малтмалын потенциалын индексийн жагсаалтад эзлэх байр дээшилжээ. Жишээ нь Казахстаны хувьд 104 орноос 45-т эрэмбэлэгдэж байсан бол 2017 онд 91 улсаас 15-д эрэмбэлэгдэж эрэмбэ сайжрав. Монгол улсын хувьд 50-аас 36-р байрт, Перу улсын хувьд 17-оос 14-р байрт дэвшин эрэмбэлэгджээ. Гэхдээ Замби улсын индексийн жагсаалтад эзлэх байр 2017 оны байдлаар 27-оос 39-р байрт ухарсан.

Ашигт малтмалын нөөц нь хөрөнгө оруулалтын шийдвэрт ихээхэн нөлөө үзүүлдэг ч хөрөнгө оруулалт татахад бүс нутгийн бодлогын орчин улам чухал болсоор байна. Бодлогын төсөөллийн индекс нь уул уурхайн бодлогын хөрөнгө оруулалт татах байдлыг эрх зүйн хүрээнд үнэлдэг.

Бодлогын төсөөллийн индексийн тооцоход ашигладаг компанийн хөрөнгө оруулалт хийх шийдвэрт нөлөөлөх 15 хүчин зүйлс:

- Засаг захиргааны ойлгомжгүй байдал, одоо үйлчилж байгаа хууль эрх зүйн дарамт
- Байгаль орчны хууль тогтоомжийн тодорхой бус байдал (хууль тогтоомжийн тогтвортой байдал, хууль эрх зүйн процессын тогтвортой байдал, хууль хэрэгжих цаг хугацаа хангалттай эсэх, хууль дүрэм нь шинжлэх ухаан дээр үндэслээгүй)
- Хууль эрх зүйн баримт бичгүүдийн үл нийцэл (үүнд улсын/орон нутгийн, мужийн/улсын, хэлтэс хоорондын давхардал гэх мэт.)
- Хууль эрх зүйн систем (эрх зүйн процессууд ил тод, авлигаас ангид, үр ашигтайгаар зохицуулах боломжтой гэх мэт.)
- Татварын дэглэм (үүнд хувийн, байгууллагын, цалин, өмч хөрөнгө, бусад татвар зэрэг хамаарна)
- Маргаантай газар өмчлөх эрхийн талаарх гомдол/хүсэлтийг шийдвэрлэхгүй, тодорхой бус байдал
- Тусгай хамгаалалтай газар нутаг, парк, археологийн олдвор зэргийн талаарх баримтлах бодлого тодорхой бус байх
- Дэд бүтэц (үүнд зам гүүр рүү нэвтрэх эрх, цахилгаан эрчим хүч хүрэлцээ болон бусад)
- Нийгэм эдийн засгийн гэрээ хэлэлцээр/(үүнд дотоод худалдан авалт, сургууль эмнэлгийн хангамж гэх мэт.)
- Тарифын хязгаар (тарифын болон тарифын бус хязгаар, ашиг бүртгэлийн хязгаарлалтууд, валютын хязгаарлалтууд, гэх мэт.)
- Улс төрийн тогтвортой байдал

- Хөдөлмөрийн хууль/хөдөлмөрийн гэрээ хэлэлцээр
- Уул уурхайн мэдээ, мэдээллийн сангийн үнэн бодит байдал
- Аюулгүй байдлын түвшин (үүнд бие болон оюун санааны аюулгүй байдал террористын халдлага, гэмт хэрэг, бүлэглэл хоорондын мөргөлдөөн гэх мэт.)
- Ажиллах хүч болон ур чадварын хүртээмж

Эдгээр хүчин зүйл дээр үндэслэн тооцоход 2016-2017 оны хооронд Монгол болон Казахстан улсын оноо ойролцоогоор 20 нэгжээр өссөн. Харин Замби Улсын оноо 20 оноогоор буурсан. Перу Улсын хувьд бууралт харьцангуй бага хэмжээнд байв.

Монгол Улсын хувьд 2016 онд 104 орноос 101-р байрт эрэмбэлэгдсэн бол 2017 онд 91 орноос 70-р байранд оржээ. Энэ нь хөрөнгө оруулагчдын хувьд газар зүйн байршил, ажиллах хүчний хангалтгүй байдал, хамгаалалттай газар нутгийн тодорхой бус байдал харьцангуй багассантай холбоотой. Казахстан Улсын хувьд 2016 онд 90-р байрт, 2017 онд 59-р байранд орсон. Үнэлгээ сайжрахад нөлөөлсөн бодлогын шинж чанартай хүчин зүйлсэд хууль эрх зүйн систем, засаг захиргааны тодорхой бус байдал, одоогийн үйлчилж байгаа хууль эрх зүй ба аюулгүй байдлын асуудал зэрэг багтжээ.

Латин Америкийн орнуудын хувьд, Перу улс Чили улсын дараа буюу 2-р байрт орж байсан. Перу Улс нь бүс нутагтаа хөрөнгө оруулалт татахад баримталдаг бодлогын хувьд хамгийн сайн нөхцөлтэй, хамгийн анхаарал татахуйц гэж дүгнэгдэж байжээ.

Перу улс 2016 онд 54-т харин 2017 онд 43-т эрэмбэлэгдсэн байна. Замби улсын хувьд бодлогын индекс 2017 онд 2016 оны 43-р байраас 71 болж буурсан байна. Энэхүү бууралт нь татварын орчин, газарзүйн мэдээ мэдээлэл, улс төрийн байдалтай холбоотой.

Хүснэгт 2. Бодлогын төсөөллийн индекс болон Хөрөнгө оруулалт татах индекс

			Монгол	Казахстан	Перу	Замби
Бодлогын индекс	Байр	2017 (91 улсаас)	70	59	43	71
		2016 (104 улсаас)	101	90	54	43
	Оноо	2017	54.23	60.91	68.99	53.34
		2016	28.08	38.77	69.54	73.61
Хөрөнгө оруулалт татах индекс	Байр	2017 (91 улсаас)	53	24	19	58
		2016 (104 улсаас)	81	73	28	30
	Оноо	2017	60.69	71.03	74.26	59.34
		2016	49.42	54.08	73.47	72.78

Source: Fraser Institute

Хөрөнгө оруулалтын индексийг тодорхойлохдоо эрдэс баялаг, бодлогын талаарх төсөөллийг аль алиныг нь авч үздэг. 2017 оны байдлаар Монгол 53, Казахстан 24, Перу 19, Замби 58-р байранд эрэмбэлэгджээ. Судалгааны хүрээнд авч үзсэн 4 улсын хувьд зөвхөн Замби улсын оноо буурсан үзүүлэлттэй байна. Монгол, Казахстан, Перу улсууд харьцангуй өндөр оноотой байна. Энэ нь хөрөнгө оруулалт татах индекс өндөр байсантай холбоотой.

Хөрөнгө оруулалт татах индекс дэлхийн хэмжээнд буурсан ч Монгол, Казахстан, Перу улсын хувьд харьцангуй сайжирсан. Энэ нь сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлсэн эрх зүйн болон бүтцийн шинэчлэлийн үр дүн юм. Fraser институтийн эрчим хүч, байгалийн баялгийн судалгаа хариуцсан захирал Kenneth Green-ий онцолсноор “Түүхий эдийн үнэ буурсан ч байгалийн баялгийн их нөөц, өрсөлдөхүйц татвар, зөвшөөрөл олголтын үр дүнтэй байдал, байгаль орчны хуулийн тогтворжилт зэрэг нь чухал хөрөнгө оруулалтыг татсаар байх болно” гэжээ.

3. Харьцуулсан шинжилгээ

Монгол, Казахстан, Перу, Замби зэрэг 4 улсыг энэхүү судалгаанд онцолж, зах зээлийн боломжууд ба хүндрэл бэрхшээлийг судалсан болно. Доорх хүснэгт улс бүрийн зах зээлийн давуу болон сул талуудыг товч дурдсан. Эдгээрийн заримыг нарийвчлан судалж, эрсдэлийн үнэлгээг хийлээ.

Хүснэгт 3. Улс орнуудын давуу ба сул талуудын харьцуулалт

	МОНГОЛ УЛС	КАЗАХСТАН	ПЕРУ	ЗАМБИ
ДАВУУ ТАЛУУД	- Асар их байгалийн баялгийн нөөц (нүүрс, зэс, алт гэх мэт.) - Орос Хятад орнуудын дунд стратегийн ач холбогдолтой газар зүйн байршил - Үйлдвэрлэлийг төрөлжүүлэх боломжтой, тэр дундаа хөдөө аж ахуйн (сүү сүүн бүтээгдэхүүн, мах, ноолуур) ба аялал жуулчлал	- Газрын тосны үйлдвэрлэл нэмэгдсэн - Гадаад шууд хөрөнгө оруулалт ихтэй - Төрийн цэвэр зээлдүүлэгч байр суурь - Хятад болон Европын дунд оршдог стратегийн газар зүйн байршил - Хөдөлмөрийн насны хүн ам харьцангуй их - Сургалтын чанарын түвшин өндөр	- Номхон далайн бүсийн улсуудын гишүүнчлэлд багтдаг - Эрдэс баялаг, эрчим хүч, газар тариалан болон загасны аж үйлдвэр хөгжсөн - Төрийн зээл харьцангуй бага - Төв банкны бие даасан байдал, банкны салбар сайн хөгжсөн - Аялал жуулчлал хөгжсөн - Хүн ам харьцангуй залуу	- Эрдэс баялгийн нөөц (Зэс: Африк тивд тэргүүлэх үйлдвэрлэгч, кобальт, уран, алт, алмаз, мангаан гэх мэт.) - Газар тариалангийн нөөц их (эрдэнэ шиш, тамхи) - Хангалттай усан цахилгаан энергийн нөөцтэй - Олон улсын санхүүгийн дэмжлэг их
СУЛ ТАЛУУД	- Эдийн засаг эрдэс баялгийн үнийн хэлбэлзлээс хамааралтай - Хятад Улсын эдийн засгаас асар их хамааралтай - Улс төрийн дотоод маргаан их - Авлигын түвшин хэт өндөр - Хүртээмжгүй уул уурхайгаас шалтгаалсан тэгш бус байдлын эрсдэл өндөр	- Эдийн засаг эрдэс баялгийн үнээс хамааралтай (газрын тос, хий, уран, төмөр) - Банкны систем эрсдэлд өртөмтгий - Хууль эрх зүй, институтын хөгжил муу: авлига ихтэй, худалдаа арилжааны саад тогтор их - Зам, эрчим хүчний дэд бүтэц хөгжөөгүй - Улс төрийн тогтворгүй байдлын магадлал өндөр - Хүн амын тоо, нягтрал ялангуяа урд хэсэгт бага	- Түүхий эд, эрэлтийн хувьд Хятадаас ихээхэн хамааралтай - Байгалийн эрсдэлд өртөх эрсдэл өндөр - Зээлийн тогтолцооны хөгжил муу - Хүртээмжгүй дэд бүтэц, эрүүл мэнд, боловсролын систем - Бүтээмж, чадамжид саад учруулдаг томоохон албан бус салбар бий болсон - Бүс нутгийн тэмцэлтэй - Какао, кокаины үйлдвэрлэл өссөн	- Зэсийн үйлдвэрлэл дээр суурилсан эдийн засагтай - Эдийн засаг төрөлжөөгүй - Зэсийн хамгийн том хэрэглэгч болох Хятад Улсаас хэт их хамааралтай, - Хөрш орнуудын эдийн засгаас хэт их хамраалтай - Эрчим хүчний нөөц хангалтгүй, гидро эрчим хүчнээс хэт их хамааралтай, тээврийн салбар найдваргүй - Эрүүл мэнд, боловсролын салбаруудын хөгжил тааруу

Эх сурвалж: COFACE

Монгол Улсын дахь эдийн засгийн өсөлтөд нөлөөлж буй гол хүчин зүйл бол уул уурхайн салбарт оруулж буй томоохон хөрөнгө оруулалт юм. Энэхүү хөрөнгө оруулалт нь эргээд барилгын салбарын хөгжлийн хөшүүрэг болж байна. Хэдийгээр уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалт нь голдуу олон улсад мөрдөгдөж байгаа эрдэст түүхий эдийн үнэ ханшаар тодорхойлогдож байгаа ч Хятадын эрэлтээр хязгаарлагдаж, Ашигт малтмалын түүхий эдийн үнийн ханш өндөр, ОУВС-ийн өргөтгөсөн хөтөлбөр хэрэгжиж байгаа ч Монгол Улсын санхүүгийн байдал эрсдэлтэй хэвээр байна. Улс төрийн хувьд ойрын хугацаанд тогтвортой байх шаардлагатай байна. Учир

нь одоогийн Засгийн газар гадаад үйл ажиллагаанд таатай хандаж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжиж байгаа.

Казахстан улсын хувьд орж ирж байгаа хөрөнгө оруулалт нь тус улсын хөгжилд тэр дундаа дэд бүтэц, зам, төмөр зам гэх мэт салбаруудад үр өгөөжөө өгсөн хэвээр байна. Учир нь Хятад Улсын “Нэг бүс, нэг зам” төслийн хүрээнд дэд бүтэц, барилгын салбаруудад хөрөнгө оруулалт хийгдэхээр төлөвлөгджээ. Kashagan газрын тос, хийн томоохон уурхайн үйлдвэрлэл нэмэгдэж байгаатай холбогдуулан, Казахстан улс өдрийн үйлдвэрлэлийн хязгаар болох 1.7 сая баррелийн квотоо дахин харж үзэхийг ОПЕКС-аас хүссэн байна.


Газрын тосны орлого буурч, зардал нэмэгдэж, валютын ханш суларч, банкны системд доголдол үүсэж засгийн газраас дэмжлэг үзүүлж байгаа ч Казахстан улсын нийт гадаад өр бага хэвээр байна. Энэ нь Үндэсний Баялагийн Сангийн нөөцөөс дээрх алдагдлыг санхүүжүүлж, эдийн засгийн уналтаас сэргийлж байгаатай холбоотой. Түүнчлэн Казахстан Улсын ерөнхийлөгч Назарбаевын өв залгамжлагчийн асуудал тодорхойгүй хэвээр байна. Казахстан улсын Ерөнхийлөгч Назарбаев одоо 78 нас хүрч байгаа ба түүний залгамжлагчийг томилох асуудал нь улс төрийн намуудын дунд маргаан өрнүүлж болзошгүй.

Перу улсын Засгийн газрын хувьд 2018 онд харьцангуй тогтвортой төсвийн бодлого баримталсан. Гол төлөв дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд, ундны усны нөөц, бохирын усны систем зэрэг салбаруудад төвлөрчээ. Өнөөгийн төсвийн алдагдал хэдийгээр харьцангуй боломжит түвшинд байгаа ч үндсэндээ эрдэс түүхий эдийн үнэ, бусад хөрөнгө оруулалтаас төсөвт төвлөрч байна. Гэхдээ авлигын асуудал газар авч байгаатай холбоотойгоор улс төрийн тогтворгүй байдал нэмэгдэж байна. Мөн хуулийн шинэчлэлт хэрэгжүүлэлттэй холбоотой асуудал үүсэж, улс төрийн тогтворгүй байдлыг үүсгээд байгаа билээ.

2018 онд зэсийн үнийн огцом өсөлттэй холбоотой Замби Улсад уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтыг ихээр нэмэгдсэн байна. Konkola, Chambishi зэрэг зэсийн уурхайнуудад өргөтгөл хийх төлөвлөгөөтэй байгаа ба ингэснээр үйлдвэрлэлийг нэмэгдүүлж шинэ хөрөнгө оруулалт татах боломж бүрдэнэ. Хэрэв Замби улс ОУВС-тай зээлийн гэрээ байгуулбал тус улсын эдийн засгийн бодлогын чиглэлд санаа зовниж байсан хөрөнгө оруулагчдад итгэл төрүүлнэ. Энэ нь ГШХО-ийн орох урсгалыг нэмэгдүүлэх юм. Замби улсын хувьд улс төрийн тогтвортой байдал, засгийн газрын үр ашигтай ажиллагаа, авлигыг бууруулах тал дээр хийж буй үйл ажиллагаа сул байгаа гэж дүгнэж болно. Мөн тус улс Хятад улстай дипломат харилцаа муудсаар байгаа. Энэ нь улс орнуудын Хятадын эсрэг үзэл баримтлал нэмэгдэж байгаатай холбоотой.

Олборлох үйлдвэрлэл нь эдийн засгийн өсөлтийн түлхүүр хөдөлгөгч хүч ба ГШХО-ыг татах гол хүчин зүйлийн нэг. Доорх хүснэгтээс харвал, 4 улсын хувьд 2000 оны эхэн үед ГШХО-ын орох урсгалын оргил үе ажиглагдсан. Улс орон бүрийн байгалийн нөөц баялгийн хэмжээ, хөрөнгө оруулалтыг татах чадвараас шалтгаалан хэмжээний хувьд өөр өөр байна. Гэхдээ тус 4 улсын хувьд ГШХО-ын орох хэмжээ нь ялгаатай байгаа ч ижил төстэй зүйл нэлээдгүй ажиглагдсан.

Зураг 8. ГШХО-ийн орох урсгал, сая ам.доллар, 1992-2017



Source: UNCTAD

Дээрх 4 улсын хувьд хөрөнгө оруулагчдын санааг зовоож байгаа гол асуудал нь авлига юм. Албан тушаалтнуудын авлигын асуудал нь хөрөнгө оруулалтын орчинд шинжилгээ хийхэд нэлээд анхаарал татахуйц байсан. Ихэнх засгийн газар авлигын эсрэг хууль эрх зүйн шинэчлэл огт хийгээгүй байсан бол зарим нь авлига авсан албан тушаалтнуудаа баривчилжээ. Казахстан болон Монгол улсын авлигын түвшин буурсан хэдий ч хангалттай хэмжээнд хүрээгүй байна.

Өөр нэг бэрхшээлтэй асуудал бол хууль дүрэм, журмын хэрэгжилт үр ашиггүй байгаа байдал юм. Энэхүү судалгаанд авч үзсэн улс орнуудын хувьд ихэнх нь дүрэм журмыг аль нэг түвшинд хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээлтэй тулгардаг байна. “Хийхэд хэцүү хэлэхэд амар” хэмээх хэлц үгийн адилаар эдгээр 4 улсын Засгийн газар авлигыг хазаарлан барьж, дүрэм журмыг чангатгана гэж хэлж байгаа ч бодит хэрэгжилт зарим талаар хангалтгүй байна.

Бүх бодлогын хэрэгжилт ГШХО-д сөрөг үр дагавартай биш юм. Жишээ нь Үндэсний баялгийн санг дээрх 4 улс бүгд байгуулсан эсвэл байгуулахаар төлөвлөсөн байна. Замби улсын хувьд баялгийн санг 2015 онд Аж Үйлдвэрийн Хөгжлийн Корпорацыг төрийн өмчит хувьцаат компанитай нэгтгэснээр байгуулахаар төлөвлөж байсан хэдий ч өнөөдрийг хүртэл хэрэгжээгүй байна. Перу улсын хувьд Төсвийн тогтвортой байдлын санг тус улсын сангийн яам нь удирддаг. Энэхүү сан нь эдийн засгийн уналтын үед төрийн орлого, зарлагын тогтвортой байдлыг хангах зорилготой.

Монгол улсын Сангийн яам Төсвийн тогтворжуулалтын сан, Ирээдүйн Өв сан гэсэн баялгийн хоёр санг удирддаг. Энэхүү сангууд уул уурхайн салбараас санхүүждэг. Төсвийн тогтворжуулалтын сан түүхий эдийн үнийн савлагаанаас эдийн засгийг хамгаалах үүрэгтэй бол Ирээдүй өв сан нь уул уурхайн салбарын орлогыг ирээдүй хойч үе дээ өвлүүлэн үлдээх зорилготой.

Казахстан улсын баялгийн сан 2000 онд үүсгэн байгуулагдсан. Тус сангийн зорилго нь дэлхийн газрын тосны үнийн савлагаанаас улс орны эдийн засгийг бүрэн хамаарах, газрын тосны хамаарлыг багасгах, ирээдүйн хойч үеийн сайн сайхны төлөө хуримтлал үүсгэхэд оршино. Тус сангийн хамгийн доод үлдэгдэл нь ДНБ-ний 30-с доошгүй хувь байх шаардлагатай гэж заажээ. Судалгаагаар Казахстан улсын сан Евроазийн бүсэд хамгийн шилдэгт тооцогддог байна.

4. Дүгнэлт ба зөвлөмж

Монгол Улс стратегийн ач холбогдол бүхий ОХУ, БНХАУ гэсэн 2 том гүрний дунд оршдог, байгалийн баялгийн асар их нөөцтэй улс юм. Гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд Монгол Улстай түншийн харилцаа тогтоох, хөрөнгө оруулалт хийх боломж нээлттэй байдаг. ГШХО-ыг нэмэгдүүлснээр гадаад худалдааг төрөлжүүлэх, өргөжүүлэхэд чиглэсэн засгийн газрын төслүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлэх замаар эдийн засаг, нийгмийн хөгжилд түлхэц үзүүлэх боломжтой юм.

Энэхүү судалгаанд Казахстан, Перу, Замби улсыг сонгосон нь тухайн улс орнуудын эдийн засаг, аж үйлдвэрийн салбарт орох ГШХО, уул уурхайн салбарын хөгжлөөс ихээхэн хамааралтай зэрэг нь Монгол Улстай ижил төстэй. Харьцуулж буй орнуудын хөрөнгө оруулалтын орчныг шинжлэх явцад ажигласнаар ГШХО-ыг дэмжих, хөнгөвчлөх тал дээр хэрэгжүүлсэн хэд хэдэн амжилттай үйл ажиллагаа байсан. Эдгээр нь бүгд хөрөнгө оруулагчдын итгэл үнэмшил, хөрөнгө оруулалтын аюулгүй байдал, өгөөжийн тодорхой байдал, гэрээний хэрэгжилтийг нэмэгдүүлэхтэй холбоотой юм. Хөрөнгө оруулагчдад энэ тал дээр баталгаа өгөхөд ил тод байдал, хариуцлага, улс төрийн тогтвортой байдал, одоогийн хууль, тогтоомжийн үр дүнтэй хэрэгжилт ихээхэн чухал.

Дээрх 4 улс орны хувьд хууль эрх зүйн болон институтийн шинэчлэл, өөрчлөлтийн хүрээнд ихээхэн дэвшил гаргасан. Мөн ГШХО-ыг татах үйл ажиллагааг хөнгөвчлөх түргэтгэх тал дээр нэлээдгүй арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. Гэхдээ бусад орнуудтай харьцуулахад зөвхөн хөрөнгө оруулалт татах чадвартай улс орнуудын онооны хувьд ахисан үзүүлэлт харагдаж, бодит байдалд энэ нь ашиглагдахгүй байгаа билээ. Илүү нарийн дүн шинжилгээ хийж үзэхэд бусад хөгжиж байгаа улс орнууд ижил төрлийн шинэчлэлийг хийсэн. Хөрөнгө оруулалт татах индексийн оноо сайжирсан хэдий ч жагсаалтад эзлэх байрт өөрчлөлт ороогүй байна. Иймээс хөрөнгө оруулагчид хөгжиж буй орнуудад ажиглагддаг хууль тогтоомжид байнга нэмэлт өөрчлөлт оруулах явдлаас хөрөнгө оруулалтаа хамгаалахын тул урт хугацааны, томоохон хөрөнгө оруулалтад тогтворжуулалтын заалтыг оруулахад анхаарал хандуулдаг. Гэхдээ нөгөө талаас энэ нь хөрөнгө оруулагчдад асуудал үүсгэж болзошгүй. Учир нь шаардлагатай, чухал нэмэлт өөрчлөлтүүд томоохон төслүүдэд хэрэгжихгүй байх тохиолдол гардаг. Зарим тохиолдолд, улс орны эдийн засагт хор хөнөөлтэй, хортой байж болзошгүй хууль тогтоомжийн цоорхойг арилгах зорилгоор нэмэлт, өөрчлөлтийг оруулдаг.

Монгол улсын Засгийн газрын үр ашиггүй, хууль эрх зүйн системийн сул байдал нь хөрөнгө оруулагчдын итгэлийг бууруулж, хөрөнгө оруулалт татахад саад болж байна. Иймд дээрх чиглэлүүдэд шинэчлэл хийх шаардлагатай байна.

Казахстан, Перу, Замби улсууд хийсэн зарим шинэчлэлийг хөрөнгө оруулалтын орчноо сайжруулах зорилгоор Монголд хэрэгжүүлэх боломжтой. Судалгааны багийн Монгол Улсын ГШХО-ын орох урсгалыг нэмэгдүүлэх талаар дараах зөвлөмжийг гаргалаа.

- ❖ Уул уурхайд орж ирж буй ГШХО-ын бусад салбар дахь шууд бус нөлөөг нэмэгдүүлэх
 - Уул уурхайн бус салбарыг дэмжих тал дээр тодорхой, хүрч болохуйц зорилтууд дэвшүүлэх
 - Уул уурхайн бус голлох салбаруудын жагсаалтыг гаргах, татвар болон хууль эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэх
 - Эдийн засгийн салбарыг төрөлжүүлэхэд худалдааны түншүүдийг зөвхөн Хятад улс, Орос улс гэж харахгүй өөр түншүүдийг бий болгох
- ❖ Орлогын менежмент
 - Төсвийн тогтворжуулалтын болон Ирээдүйн өв сангийн төлөвлөгөөг чангатгах

- Хэрэгжүүлж байгаа өөрчлөлт шинэчлэлт нь богино хугацааны үр өгөөжгүй байгаад анхаарал хандуулах
- ❖ Хөрөнгө оруулагчдад зориулсан “Нэг цэгийн үйлчилгээ”
 - Энэхүү үйлчилгээ нь цахим хэлбэрээр эсвэл хүнээс хүнд үйлчилгээ үзүүлдэг байх
 - Холбогдох зөвшөөрөл лицензийг авахад дэмжлэг туслалцаа үзүүлэх
 - Гадаадын иргэдэд бизнес эхлүүлэх боломж бүрдүүлэх, процессыг хурдасгах
- ❖ Тогтворжуулах нөхцөл
 - Хэрэв тогтворжуулах нөхцөлийг хэрэгжүүлсэн бол өөр эх үүсвэрийн орлогоос ашиг хуримтлуулах боломжийг алдахгүйн тулд гэрээний хугацааг хязгаарлах хэрэгтэй.
 - Тогтворжуулах нөхцөлийг хэрэгжүүлэхгүй байх нь томоохон хөрөнгө оруулагчдыг алдах эрсдэлтэй. Учир нь хөрөнгө оруулагчид тогтвортой байдлыг илүүд үздэг.
- ❖ Авлига
 - Засгийн газрын авлигын эсрэг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх
 - Томоохон хөрөнгө оруулалтуудын ил тод байдлыг нэмэгдүүлэх
- ❖ Ил тод байдал ба Хариуцлага
 - Томоохон төслүүдийн хөрөнгө оруулалтын гэрээг олон нийтэд ил тод болгох
 - Олон нийтийн санаа бодлыг тусгахын тулд хэлэлцээрийн явцад иргэний бүлгүүдийг оролцуулах
 - Одоогийн нөхцөл байдалд үндэслэн засгийн газарт давуу эрх олгохын тулд хууль тогтоомжид ойр ойрхон нэмэлт өөрчлөлт оруулахгүй байх хэрэгтэй. Учир нь энэхүү давтамжтай шинэчлэлт нь хөрөнгө оруулагчдад эргэлзээ үүсгэдэг.

АШИГЛАСАН НОМ, ТОВХИМОЛ

- Bank of Mongolia. (2018). *Balance of Payments*. Ulaanbaatar: Bank of Mongolia.
- Byambasuren, B. (2019, February 12). ГШХО ӨМНӨХ ОНООС 422 САЯ АМ.ДОЛЛАРООР ӨССӨН Ч УУЛ УУРХАЙ, МЕГА ТӨСЛҮҮДЭД ТӨВЛӨРЧЭЭ. Retrieved from BloombergTV: <http://bloombergtv.mn/>
- COFACE SA. (2018). *Economic Studies: Kazakhstan*. Bois-Colombes.
- COFACE SA. (2018). *Economic Studies: Mongolia*. Bois-Colombes.
- COFACE SA. (2018). *Economic Studies: Peru*. Bois-Colombes.
- COFACE SA. (2018). *Economic Studies: Zambia*. Bois-Colombes.
- Economic Research Institute. (2017). *FDI Inflow in Mongolia*. Ulaanbaatar.
- Economic Research Institute. (2018). *FDI Inflow in Mongolia Update Report*. Ulaanbaatar.
- Forneris, X., Gomez Altamirano, D., Chun, D. E., Kher, P., Khuu, K., Koffi, K. A., . . . Whyte, R. (2018). *Investment Reform Map for Mongolia: A Foundation for a New Investment Policy and Promotion Strategy*. Washington, D.C.: World Bank Group.
- Jackson, T., & Green, K. P. (2017). *Annual Survey of Mining Companies: 2016*. Vancouver: Fraser Institute.
- Nurshayeva, R. (2016, July 05). *Kazakhs, Chevron-led group approve \$37 billion Tengiz field expansion*. Retrieved from Reuters: <https://www.reuters.com/article/us-chevron-kazakhstan/kazakhs-chevron-led-group-approve-37-billion-tengiz-field-expansion-idUSKCN0ZLOX4>
- OECD. (2017). *OECD Investment Policy Reviews: Kazakhstan 2017*. Paris: OECD Publishing.
- Samruk Kazyna. (2018). *Comprehensive Privatisation Plan for 2016-2020*.
- Schmitz, C. (1986). The Rise of Big Business in the World Copper Industry 1870-1930. *The Economic History Review* Vol 39, 392-410.
- Stedman, A., & Green, K. P. (2018). *Fraser Institute Annual Survey of Mining Companies 2017*. Vancouver: Fraser Institute.
- Transparency International. (2018). *Corruption Perceptions Index 2018*. Berlin: Transparency International.
- U.S. Department of Commerce. (2018). *Kazakhstan Country Commercial Guide*. Washington, D.C.
- U.S. Department of State. (2018). *Investment Climate Statement 2018: Kazakhstan*. Washington, D.C.
- U.S. Department of State. (2018). *Investment Climate Statement 2018: Mongolia*. Washington, D.C.
- U.S. Department of State. (2018). *Investment Climate Statement 2018: Peru*. Washington, D.C.
- U.S. Department of State. (2018). *Investment Climate Statement 2018: Zambia*. Washington, D.C.
- UNCTAD. (2013). *Investment Policy Review: Mongolia*. New York and Geneva: United Nations.

UNCTAD. (2018). *World Investment Report 2018: Investment and New Industrial Policies*. Geneva: United Nations.

World Bank. (2018). *World Bank Commodity Price Data (The Pink Sheet)*. Washington, D.C.

World Bank. (2018). *World Development Indicators*.

World Bank. (2019). *Doing Business 2019: Training for Reform*. Washington, DC: World Bank.

World Trade Organization. (2013). *Trade Policy Review: Peru*. Switzerland: WTO.